



2012

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Агуулга

Агуулга	01
Өмнөх үг	02
Товчилсон үгс	03
Хүснэгт	04
Зураг	04
Шийтгээ	04
Хураангуй	04
1. ОРШИЛ	05
2. СУДАЛГАНЫ АРГА ЗҮЙ	07
3. КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ	09
3.1. Монгол Улс: Улс төр, нийгэм ба эдийн засаг	10
3.2. Төр, эдийн засаг, нийгмийн уялдаа холбоо	14
3.3. КНХ-ын өнөөгийн байдал	15
3.3.1. Компанийн нийгмийн харууллагын төрийн бодлого /Төрийн байгууллагууд /	17
3.3.2. Компанийн нийгмийн харууллагын төрийн бодлого /Төрийн бус оролцогчид /	20
3.4. Компанийн нийгмийн харууллагын төрийн бодлого /Баримт бичиг, үйлт ажиглалага /	22
3.4.1. Заавал биелүүлэх хүрээ	22
3.4.2. Зөөлөн хууль	25
3.4.3. Санаачлага ба Түншлэл	28
3.4.4. Урамшууллын бодлого	29
3.4.5. Мэдлэг олгох үйл явц	32
4. ДҮГНЭЛТ	33
5. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	37
Хавсралт 1. КНХ-ын хөгжлийн түвшинг тодорхойлох шалгуурууд	41
Хавсралт 2. КНХ-ын асуудлаар дүн шинжилгээ хийсэн хууль тогтоомжийн жагсаалт	45
Ашигласан материал	48

Эрхлэн гэрлэсэн:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)
Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага (ЭТИС) хөтөлбөр

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Нэгдсэн Үндэсний гудамж 5/1, 38-р байр, 3 давхар
210236 Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: +976 7011 7704
Факс: +976 7011 7705
И-мэйл: iml@giz.de
Вэб: www.giz.de
Зураг: © GIZ

Энэхүү судалгааг "Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Санаачлага хөтөлбөр"-ийн захиалгаар СУДАЛГАД, ЗӨВЛӨГӨӨ ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ТӨВ ХХК ЭН АР СИ СИ ХХК гүйцэтгэв.

ӨМНӨХ ҮГ



Нийгмийн харилцааг чандлан биелүүлэх замаар уул уурхайн тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэн дэмжих нь Монгол Улсын ирээдүйн нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой юм. Монгол Улсын ашигт малтмалын баялаг эдийн засгийн өсөлтөд асар ихээр нөлөөлж, олон улсын томоохон уул уурхайн компаниудыг татаж байна. Тиймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой орчныг цогцлоон бүрдүүлж, үр өгөөжийг нь нэмэгдүүлэх бодит боломж бидэнд бий. Гэхдээ уул уурхайн үйлдвэрлэл нь өөрөө байгаль орчин, нийгэм, эдийн засгийн бодит хөгжилд ноцтой эрсдэл учруулдаг бөгөөд сүүлийн 10 гаруй жилд энэ явдал даамжирсаар байна.

ГОУХАН нь Эрдэс баялаг, Түүхий эдийн Иж бүрэн Саначлага (ЭТИС) хөтөлбөрөөрөө дамжуулан Монгол шиг шилжилтийн эдийн засагтай улс орнуудын хувьд Компанийн Нийгмийн Харилцаа (КНХ) хэр их ач холбогдолтой байдлаа талаар тодорхойлж, анхаарал хандуулан ажиглаж байна. ЭТИС хөтөлбөрөөс “Өрсөлдөх чадвар ба – КНХ, Харилцаагаа ухамсарласан аж ахуйн нэгж эдийн засгийн тогтвортой хөгжлийн төлөө юу хийх ёстой вэ?” сэдэвтэй олон улсын бага хурлыг 2011 оны 9-р сард зохион байгуулан, КНХ-ын талаар сонирхолтой, үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлсэн нь энэ чухал асуудлын ач холбогдлыг таниулахад томоохон түлхэц болсон билээ. Үүний зэрэгцээ ЭТИС хөтөлбөр нь энэхүү олон улсын бага хурлаас гарсан үр дүнд тулгуурлан Монгол Улс дахь КНХ-ын өнөөгийн байдлаа судалгаа буюу дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийсэн юм.

Монгол шиг өндөр хурдацтай хөгжиж буй эдийн засагтай оронд КНХ-ын асуудал ямар түвшинд байгааг зөвхөн монголчууд өөрсдөө тодорхойлж чадна. КНХ-ын чадавхийг бүрэн дайлахад нийгэм, байгаль орчны үрэг харилцааг үүрэхэд бэлэн байгаа бизнесийн болон иргэний нийгмийн төлөөлөгчдийн аль аль нь оролцох шаардлагатай. Гэхдээ тогтвортой хөгжил нь зөвхөн дээрх хоёр салбарын төлөөлөгчдийн оролцоо биш, харин бүх оролцогч талын хамтын ажиллагааг хангах бодлогын таатай орчныг шаардаж байна. Тиймээс төр, засгийн байгууллага нь бүх оролцогч талын хамтын ажиллагааг чиглүүлэн, зохицуулахад анхаарахын зэрэгцээ хувийн хэвшлийн төлөөлөгчид хамтрахад дэмжлэг үзүүлэх чухал үүрэг гүйцэтгэх юм.

Монгол Улсад КНХ-ыг хөгжүүлэхэд бизнесийн салбар, иргэний нийгэм, төрийн байгууллагуудын хоорондын холбоо, хамтын ажиллагааны талаар ойлголт хомс байна. Үйл ажиллагааг удирдан явуулах үндсэн байгууллага болон хувь хүмүүс, мөн үндэс оролцох гол хүмүүс нь хэн байх вэ? Тогтвортой, харилцаатай уул уурхайн талаар ямар ойлголттой, мөн Монгол Улсын болон олон улсын уул уурхайн компаниудад ямар ашигтай, хувь нэмрээ хэрхэн оруулах вэ? Санхүү, харилцаа холбоо, тээвэр зэрэг бусад үндсэн үйлдвэрлэл ямар үүрэг гүйцэтгэх вэ? Уул уурхайн компаниуд болон холбогдох ажилчид, албан хаагчид дээрээс доошоо, эсвэл доороос дээшээ чиглэсэн үнэлэмжийн хүрээнд харилцаатай бизнесийн туршлагудыг бий болгохдоо ямар бодлого баримталдаг вэ? Монгол Улсын хэмжээнд КНХ-ын олон улсын асуудлыг хэрхэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх вэ? Эцэст нь Монголын төр КНХ-ыг бий болгох үндэсний стратегийг боловсруулахад ямар ажлын орчин, ямар нөхцөл хэрэгтэй вэ?

Энэхүү судалгааны ажлаар дээр дурдсан олон асуултад хариулт өгөх боломжтой болох юм. Судалгаанаас харахад улсын салбар, бизнесийн хамтын ажиллагаа, иргэний нийгэм нь КНХ-тай холбоотой асуудлуудын ач холбогдлын талаар нэлээд дэлгэрэнгүй ойлголттой болж үйл ажиллагаа эрхлэх хүсэл сонирхол илүү хүчтэй болж эхэлж байна. Гэхдээ КНХ-ын талаар олон талаас, өөр өөр өнцгөөс нь ойлгох явдал хэвээр үлджээ. Бизнесийн үйл ажиллагаанд оролцож буй олон талын үүрэг харилцааны талаар нэгдсэн ойлголт, тодорхойлолт хязгаарлагдмал байна. Тиймээс энэ судалгааны ажилд дээр дурдсан гурван үндсэн салбар болох бизнес, иргэний нийгэм, төрийн байгууллагууд ашиглахад тохиромжтой хэд хэдэн зөвлөмжийг тусгалаа.

ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн зүгээс энэ судалгааны ажлыг гүйцэтгэхэд өөрсдийн үнэтэй санал бодол, мэдлэг туршлагаа хуваалцаж гүн тулалцаа үзүүлсэн бүх хувь хүмүүс болон байгууллагуудад чин сэтгэлийн талархал илэрхийлвэ.

Др. Штефан Хансегелманн
ГОУХАН-ийн “ЭТИС” хөтөлбөрийн захирал
2012 оны 9-р сар

Товчилсон үгс

▶ БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
▶ ГЕГ	Гаалийн ерөнхий газар
▶ ГОУХАН	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
▶ ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
▶ ЗГТС	Засгийн газрын тусгай сан
▶ ЗТБХБЯ	Зам тээвэр барилга, хот байгуулалтын яам
▶ КНХ	Компанийн нийгмийн харилцлага
▶ МАОЭНХ	Монголын ажиг олгогч эздийн нэгдсэн холбоо
▶ МБ	Монгол банк
▶ МБХ	Монголын банкуудын холбоо
▶ МҮХААҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
▶ МҮЭХ	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо
▶ МХБ	Монголын хөрөнгийн бирж
▶ ННФ	Нээлттэй нийгэм форум
▶ НХХЯ	Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам
▶ ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
▶ КЗХТ	Компанийн засаглалын хөгжлийн төв
▶ КЗҮЗ	Компанийн засаглалын үндэсний зөвлөл
▶ УСХ	Үндэсний статистикийн хороо
▶ УХШХ	Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо
▶ СЭХ	Санхүүгийн зохицуулах хороо
▶ СХЗГ	Стандартчилал хэмжил зүйн газар
▶ СЯ	Сангийн яам
▶ ТӨХ	Төрийн өмчийн хороо
▶ ТЕГ	Татварын ерөнхий газар
▶ ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
▶ ХЭЖК	Хүний эрхийн үндэсний комисс
▶ ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
▶ ЭТИС	Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага
▶ ӨНЭЭС	Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа

Хүснэгт

- Хүснэгт 1. Хоёрдогч эх үүсвэр материал
- Хүснэгт 2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд
- Хүснэгт 3. КНХ-ын төрийн оролцогч
- Хүснэгт 4. КНХ-ын төрийн бүс оролцогч
- Хүснэгт 5. КНХ-д холбоотой хууль тогтоомж
- Хүснэгт 6. КНХ-д холбогдох санаачлага

Зураг

- Зураг 1. ДНБ-ний өсөлтийн хурд, 1990-2009
- Зураг 2. Дэлхийн банкны засаглалын индикаторууд /1996-2010, Монгол Улс /
- Зураг 3. КНХ-ыг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө

ШИЛТГЭЭ

- Шилтгээ 1. Компанийн нийгмийн харилцлага хэмээх нэр томъёог оновчтой болгох
- Шилтгээ 2. Компанийн Нийгмийн Харилцлалтын талаарх ойлголт
- Шилтгээ 3. Их Британийн КНХ-ын асуудал харилцсан төрийн оролцогч

Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Төрөөс КНХ-ын талаар баримтлах бодлого Улсын компаний нийгмийн харилцлалтын (КНХ) төрийн бодлогын өнөөгийн байдлыг зарим ТББ, хувийн хэвшил идэвхтэй судлан, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид оролцож байна.

Хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах юм. Судалгаанаас харахад КНХ нь Хэдийгээр хууль тогтоомжид КНХ-Монгол Улсын хувьд нэлээд шинэлэг ын талаар наад захын стандартыг ойлголт бөгөөд эхлэл шатандаа явж мөрдүүлэхээс эхлүүлэн ажлын байр байна. Одоогийн байдлаар төрийн болон нэмэгдүүлэх, дэвшилт технологийн бүс оролцогчдын аль аль нь КНХ-нэвтрүүлэх, байгаль орчинд хоргүй арга ыгчухал ач холбогдолтой гэж үзэж байгаа төхник ашиглах зэрэг үйл ажиллагааг нь сайшаалтай болгох энэ талаар нэгдсэн урамшуулсан дэмжих бодлого туссан ч ойлголт байхгүй бөгөөд ойлголтууд нь өөр хуулийн хэрэгжилт хангалтгүй, зарим хоорондоо зөрчилдөж байна. заалтыг хэрхэн хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байгаа зэргийн улмаас тодорхой үр дүнд хүрч чадахгүй байна.

УХШХ болон КЗҮЗ нь компанийн Энэ нь КНХ-ын талаар нэгдсэн ойлголт, засаглалын хүрээнд КНХ-ыг харилцан ажигладаг гол байгууллагууд бөгөөд тодорхойлолт бий болгоүй, тухайн эдгээр байгууллагаас гадна Засгийн газар, асуудлыг нэгтгэн харилцдаг төрийн СЯ, НХХЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ, БОАЖЯ, байгууллага байхгүй зэргээс шалтгаалж ТЕГ, ГЕГ, СХЗГ, ЗГТС, ИТХ, байж болж юм.

Оршил

Өнөөдөр дэлхийн улс орнууд тогтвортой хөгжил буюу өнөө үеийнхний үндсэн хэрэглээ, амьдралын чанарыг ирээдүй үеийнхний амьдралын чанарт нөлөөлөхгүйгээр сайжруулах зорилгыг өмнөө тавьж байна. Өнөө үеийнхний төлөө гаргаж буй аливаа шийдвэр нь алсыг харсан буюу ирээдүй үеийнхний хүний эрх, чөлөөт сонголт, амьдралын чанарыг бууруулахгүй байхад чиглэсэн байх ёстой.

Монгол Улс тогтвортой хөгжлийн чиг хандлагаа Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод “хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлт, монгол хүний хөгжил, түүний дотор боловсрол, эрүүл мэнд, түүнчлэн шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг тэргүүлэх чиглэл болгох”⁽¹⁾ хэмээн тодорхойлж, эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төр, иргэний нийгмийн хүлээх үүрэг хариуцлага, хамтын ажиллагааг тодорхой зааж өгсөн. Тогтвортой хөгжилд хүрэхэд нийгмийн бүхий л талын оролцоо нэн чухал бөгөөд компаниуд ч энэ хариуцлагаа ухамсарлах болсон нь нийгмийн хариуцлагын хөтөлбөртэй компаниудын тоо нэмэгдэж байгаагаас харгалдаж байна. Нөгөө талаас иргэний нийгэм ч өөрсдийн оролцооны хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болжээ.

Тогтвортой хөгжилд хүрэхэд идэвхтэй оролцоо төдийгүй идэвхтэй, үр ашигтай хамтын ажиллагаа чухал юм. Иймд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн зорилгын төлөө хооронд нь уялдуулах, зохицуулах, идэвхтэй оролцоог нь дэмжих явдал төрийн нэг чухал үүрэг болж байна.

Энэ зорилгын хүрээнд, Бертелсман Штифтунг болон Германы Опон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг хамтран “CSR Navigator: Public Policies in Africa, the Americas, Asia and Europe” нэртэй КНХ-ын бодлогын судалгааг анх удаа хийсэн бөгөөд 13 орны КНХ-ын бодлогод системтэй шинжилгээ хийн, компанийн нийгмийн оролцоог дэмжихэд хамгийн сайн бодлогын арга хэрэгслийг харуулахыг зорьсон байна.⁽²⁾



(1) Мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008.01.31
(2) CSR Navigator: Public Policies in Africa, the Americas, Asia and Europe, GTZ and Bertelsman Stiftung, 2007

Судалгааны арга зүй

2

Түүнчлэн судалгааны тайлан, тоон мэдээлэл, КНХ-ын тайлан зэрэг материалуудад дүн шинжилгээ хийж, Монголын байгууллагуудын Цахим хуудсанд КНХ-ын талаар хэр зэрэг мэдээлэл байгааг судалж үр дүнг нэгтгэн хавсралтад оруулсан болно. Энэ хүрээнд гадаадын байгууллагуудын гаргасан судалгаа, тайлан, тоон мэдээллийг мөн ашигласан.

Уг судалгааг хоёрдогч эх үүсвэр материалд дүн шинжилгээ хийх болон ярилцлагын аргад тулгуурлан хийсэн. Ярилцлагыг КНХ-ын асуудалд хамаарал бүхий, эсвэл энэ чиглэлээр харуудан ажиглаж байгаа гэх хоёр хүрээнд төр, ТББ-ын төлөөллийг оролцуулан зохион байгуулав.

Судалгааны хүрээнд КНХ-ын хүрээнд авч үздэг хүний эрх, байгаль орчин, хөдөлмөр, татвар, нийгмийн даатгал, хэрэглэгч, авлигатай тэмцэх хүрээний нийт 80 орчим хуульд судалгаа хийсэн. КНХ-ын хүрээнд дүн шинжилгээ хийсэн хуулиудын жагсаалт болон дүн шинжилгээ хийсэн тайланг хавсаргасан болно.

Хоёрдогч эх үүсвэр, материал

М-ын бодлогын баримт бичгүүд
КНХ-тай холбоотой зохицуулалт орсон байж болох нийт 80 орчим хуулийг судалсан.

М-ын бодлогын баримт бичгүүд
Тогтвортой хөгжил, компанийн засаглал, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэл, хүний эрхийн чиглэлээр батлагдсан 10 орчим үндэсний хөтөлбөр

Судалгааны тайлан, тоон мэдээлэл
ННФ, МУИС болон бусад байгууллагын хийсэн судалгаа, тоон мэдээлэл

Аж ахуй нэгжүүдийн КНХ-ын тайлан
МУХАУТ-аас эрхлэн 49 компанийн КНХ-ын тайланг нэгтгэсэн эмхэтгэл, 2007 он

Хурлын тайлан
Өрсөлдөх чадвар ба компанийн нийгмийн харуулцаа*, ГОУХАН, 2011 он

Байгууллагуудын цахим хуудас
Төрийн байгууллага, 6 ТББ, 8 компанийн цахим хуудаст дүн шинжилгээ хийсэн.

CSR Navigator: Public Policies in Africa, the Americas, Asia and Europe
ГТХАН/ГОУХАН/ болон Бергеломан Штифтунг хамтран 13 улсын КНХ-ын талаарх төрийн бодлого, түүний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээний тайлан, 2007 он

Их Британийн КНХ-ын талаарх материал
Английн КНХ-ын бодлогын талаарх тайлангууд, бодлогын бичиг баримт, цахим хуудасны мэдээлэл зэргийг ашигласан.

UN Global Compact, ISO 26000
www.unglobalcompact.org, www.iso.org

“Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц” хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан
Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн Хороо хөтөлбөрт хяналт, шинжилгээ хийж, тайлангаа 2011 онд нийтэлсэн. Тайланд КНХ-д хамааралтай хэд хэдэн заалт тусовч болно.

Хүснэгт 1. Хоёрдогч эх үүсвэр материал

Компанийн нийгмийн Харууллагын талаарх Монгол Улсын Төрийн бодлого, түүний хэрэгжилт

3

3.1. Монгол Улс: Улс төр, нийгэм ба эдийн засаг

Монгол Улс нь 2.75 сая хүн амтай⁽³⁾, далайд гарцгүй орон бөгөөд ОХУ ба БНХАУ-тай хиллэдэг. Парламентын засаглалтай бөгөөд төрийн эрх барих дээд байгууллага нь Монгол Улсын Их Хурал юм⁽⁴⁾, Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийн бэлгэдэл мөн. Төрийн гүйцэтгэх дээд байгууллага засгийн газар бөгөөд нийт 11 яамтай⁽⁵⁾. Шүүх эрх мэдлийг гэгцхүү шүүх хэрэгжүүлнэ хэмээн Монгол Улсын Үндсэн хуульд заасан.

Үзүүлэлт	Эх үүсвэр
ДНБ, ам.доллар	6.2 тэрбум (2010) Дэлхийн банк
ДНБ-ий өсөлтийн хурд	6.4% (2010) Дэлхийн банк
Ажилгүйдлийн түвшин, жилийн дундаж	10.2% (2007-2010) УСХ
Бүтээгдэхүүн, үйлчилгээний импорт	52% (2010) УСХ
Бүтээгдэхүүн, үйлчилгээний экспорт	47% (2010) УСХ
Авлигын хандлагын индекс, CPI	2.7 (2010) Транспаренси Интернешнл
Жини индекс	0.33 (2010) ӨНЭЭС
Ялдуурлын түвшин	35.2% (2008) Дэлхийн банк
Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь	3.9% УСХ
Хүний хөгжлийн индекс	0.653 (2011) НҮБ
Төрийн эрүүл мэндийн зарлага, ДНБ-д эзлэх хувь	4.0% (2009) Дэлхийн банк
Төрийн боловсролын зарлага, ДНБ-д эзлэх хувь	5.4% (2010) Дэлхийн банк

Хүснэгт 2. Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

(3) Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллого, нэгдсэн дүн, УСХ, Улаанбаатар, 2011
(4) Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, 20-р зүйл
(5) Засгийн газрын бүтцийн тухай хууль, 2008 он, 1-р зүйл

Монгол Улс 1990 оныг хүртэл 70 орчим жил социалист системээр замнасан бөгөөд чөлөөт, ардчилсан нийгэмд шилжээд 20 гаруй жил л болж байна.

Ганц намын тогтолцоотой социалист системийн үед МАХН улс төрийн ганц хүчин байсан бол олон намын тогтолцоотой өнөө үед бүртгэлтэй хориод улс төрийн нам үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс МАН болон АН гэсэн улс төрийн хоёр том нам Монголын улс төрд зонхилж байр суурийг эзэлж, ардчилсан тогтолцоонд шилжсэн жилүүдэд дөнгөар болон хамтран төр барьж ирсэн. МАХН 2011 онд нэрээ өөрчилж МАН болсон бөгөөд бодлого нь уг намын суурь болох зүүний үзэл баримтлалд суурилдаг. АН нь ардчиллын үед төрсөн шинэ залуу нам бөгөөд үзэл баримтлалын анхны суурь нь барууны буюу хувийн өмчид суурилсан чөлөөт өрсөлдөөнийг дэмжих явдал байсан юм.


Зах зээлийн тогтолцоонд шилжсэн эхний жилүүдэд МАХН болон АН нь зах зээлийн харилцааны үндсийг тавихад голлон анхаарч, улс төр болон эдийн засгийн бодлого нь эдийн засаг дахь төрийн оролцоог хумихад чиглэж байсан. Энэ үед үнийн чөлөөлж, өмч хувьчлалыг эрчимтэй явуулсан. Өмч хувьчлал нь өмчийн олон талт харилцаа хөгжиж, улмаар хувийн хэвшил шинээр бий болох, эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурь нэмэгдэхэд түүхэн чухал үүрэг гүйцэтгэсэн гэж эдийн засагчид үздэг⁽⁶⁾. Үүний дүнд хувийн хэвшил Монгол Улсад томоохон байр суурьтай болж 2010 оны байдлаар ДНБ-ий 73.4 хувийг үйлдвэрлэж байна.

Харин уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж ирсэн сүүлийн жилүүдэд улс төрийн гол нэмүүд зүүний чиглэл буюу эдийн засаг дахь төрийн оролцоог нэмэгдүүлэх байр суурь баримтлах болжээ. Сүүлийн 2 сонгуулийн хугацаанд гол хоёр нам хамтарсан засгийн газар байгуулан ажиллаж ирсэн бөгөөд энэ нь нийгмийн халамжийг нэмэгдүүлэх, төрийн оролцоог өсгөх зэрэг асуудал дээр мөрийн хөтөлбөр нь төдийлэн ялгарахгүй байсантай холбоотой юм.

Тухайлбал, 2008 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдээс харахад энэ хоёр нам нийгмийн хамгааллын бодлогын зардлыг их хэмжээгээр нэмэхээр тусгасан байдаг. Ц.Батсүхийн 2008 оны намудын мөрийн хөтөлбөрт хийсэн шинжилгээгээр сонгуулиар амалсан нийгмийн халамжийн бодлогод 2011 онд АН 1.7 их наяд төгрөг, МАХН 2.2 их наяд төгрөг зарцуулахаар тооцоо гарсан байна⁽⁷⁾.

Тиймээс ч сонгуулиар гарч ирсэн хоёр том намын хамтарсан засгийн газрын мөрийн хөтөлбөрт нийгмийн халамжийн бодлого томоохон байр суурь эзэлж байна.

2008 онд байгуулагдсан хамтарсан засгийн газрын мөрийн хөтөлбөрт стратегийн болон томоохон орд газраас олсон орлогоос иргэн бүрт 1.5 сая төгрөг хүртээх, шинээр гэр бүл болоход, нийт болон шинэ төрсөн хүүхдэд мөнгөн тусламж, тэтгэмжийг үргэлжлүүлэн олгох, шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн гэр бүлд нэг удаа 300.0 мянган төгрөг олгох, “Эхийн алдар” хоёрдугаар зэргийн одонтой эхэд 500.0 мянга, нэгдүгээр зэргийн одонтой эхэд 1.0 сая төгрөгийн тэтгэмж олгох, цалин тэтгэвэр тэтгэмжийг 2008 оны түвшнээс 3 дахин өсгөнө гэж заасан⁽⁸⁾. Эдгээр бодлогын нөлөөгөөр төсвийн зарлага ихээхэн өсч 2011 оны байдлаар төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин 50 гаруй хувьд хүрсэн байна.



Зураг 1. ДНБ-ний өсөлтийн хүрээ, 1990-2010

Эх үүсвэр: Статистикийн жилийн эмхтгэл 1990-2010, УСК

Зах зээлийн эдийн засагт шилжих үй явцад Монгол Улс шилжилтийн эхэн үеийн эдийн засгийн гүнзгий хямралыг даван туулсан. 1993 онд ДНБ 1989 оны түвшнээс бараг дөрөвний нэгээр бага буюу 22.3 хувиар доогуур байсан нь энэ хямрал хэр гүнзгий байсныг тод харуулж байгаа юм. Энэхүү уналтын улмаас Монгол Улсын үйлдвэрлэл 2002 онд л 1989 оны түвшинг гүйцэж ирсэн. Харин хүн амын амьжиргааны түвшний нэг хэмжүүр болох нэг хүнд ногдох ДНБ 2005 онд л 1989 оны түвшинг гүйцсэн байна. 2004 оноос Монгол Улсын эдийн засаг эрчимтэй өсч ирсэн бөгөөд 2011 онд ДНБ 17.3 хувийн өсөлттэй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засагт уул уурхайн салбар томоохон байр суурь эзлэх боллоо. 2010 оны байдлаар уул уурхайн салбар ДНБ-ий 22.7 хувийг үйлдвэрлэдэг хамгийн том салбар болсон бөгөөд эрдэс бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 81 хувийг эзэлж байна. Эндээс харахад уул уурхайн салбарын нөлөөгөөр эдийн засаг улам бүр өрөөсгөл, түүхий эдээс хараат бүтэцтэй болох хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд орлогын ялгаа их, ядуурлын түвшин өндөр байсаар байна. УСК- ны мэдээлснээр 2008 онд Жини коэффициент 0.36⁽⁹⁾, ядуурлын түвшин 35.2 хувь байсан бол 2010 онд ядуурлын түвшин 39.2 хувь байна. Түүнчлэн уул уурхайн салбар нь хөрсний доройтол, агаварын болон усны бохирдлыг ихэсгэх нөлөө үзүүлэх болсон.


Уул уурхайн салбарын эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлж буй энэхүү нөлөөлөл нь иргэд, олон нийт, бодлого боловсруулагчдын анхаарлыг татаж байна.

Уул уурхайн салбар хөгжихийн зэрэгцээ “баялгийн хараал” аас зайлсхийх тухай ихээхэн яригдах болсон. “Баялгийн хараал” аас зайлсхийхэд хамгийн гол хүчин зүйл нь институцийн хөгжил, сайн засаглал гэж үздэг. Харин сүүлийн жилүүдэд эдийн засаг дахь төрийн оролцоо улам нэмэгдэх, засаглалын чанар улам муудах хандлага ажиглагдаж байна.

(6) Монголын эдийн засагт хувьчлалын үзүүлсэн нөлөө, Улаанбаатар, 2011
(7) Нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр нам, засгуудийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийсэн харьцуулсан судалгаа (2008-06-24), доктор Ц. Батсүх, lib.ub.edu.mn/
(8) Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 2008-2012, www.oreen.gov.mn/oreen.html

(9) Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгаа, 2007.07-2008.06 сар, УСК

Зураг 2. Дэлхийн банкны засаглалын индексаторууд, 1996-2010, Монгол Улс



Эх үүсвэр: Daniel Kaufmann, Aart Kraay and Massimo Mastuzzi (2010). "The Worldwide Governance Indicators: A Summary of Methodology, Data and Analytical Issues". World Bank Research Working Paper No. 5430

Дэлхийн Банкны засаглалын индексаторуудыг (Governance Indicators⁽¹⁰⁾) зураг 1-д үзүүлэв. Монголын засаглалын чанар ерөнхийдөө муудах хандлагатай байгаа бөгөөд ялангуяа засгийн газрын үр ашгтай байдал болон авлигын үзүүлэлтүүд эрс муудсан байдал харагдаж байна.

Түүнчлэн Транспаренси интернэйшнл байгууллагаас гаргадаг авлигын хандлагын индекс (Corruption Perception Index⁽¹¹⁾) үзүүлэлт 2009-өөс 2011 онд 3-аас 2.7 болж буурсан бөгөөд 2011 онд 183 улс орноос Монгол Улс 120-р байрт жагсаж байна. 2009 онд Монгол Улсын Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанаас хийсэн Авлигын индексийн судалгаагаар судалгаанд оролцсон иргэдийн 81.1 хувь нь Монгол Улсад авлига түгээмэл, 80.0 хувь нь төрийн албан хаагчид ажиглагдаа харуулдаггүй ханддаг гэдэгтэй ямар нэгэн хэмжээнд санал нийлж байна гэж харуулсан нь иргэдийн төрд итгэх итгэл сүл байгааг харуулж байна.⁽¹²⁾

3.2. Төр, эдийн засаг, нийгмийн уялдаа холбоо

Монгол Улс 1990 онд ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш олон намын тогтолцоотой, чөлөөт ардчилсан нийтэм байгууллахаар зорьж байна. Иргэд үзэл бодлоороо чөлөөтэй эвлэлдэн нэгдэх эрхтэй болсон бөгөөд энэ хугацаанд Монголд иргэний нийгмийн байгууллагууд огноороо бий болсон.

Иргэний нийгмийн гол бүрдэл хэсэг нь төрийн бус байгууллага (ТББ) бөгөөд УСХ-ны мэдээлснээр 2010 онд нийт 6915 төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Иргэний нийгмийн байгууллагууд нь байгаль орчин, нийгмийн эмзэг бүлгийн эрх ашиг, хөдөлмөр, цалин хөлс зэрэг нийгмийн олон асуудлаар үйл ажиллагаа явуулдаг. Хөдөлмөр, цалин, тэтгэмжийн асуудлаар ялангуяа үйлдвэрчний эвлэлүүд маш их идэвхтэй ажиллаж байна. Түүнчлэн нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх тусламж, нийгмийн хамгааллын асуудлаар олон тооны ТББ үйл ажиллагаа явуулдаг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад уул уурхайн салбар дахь иргэний нийгмийн оролцоо идэвхжиж байна. 2008 оны байдлаар байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 308 бүртгэлтэй ТББ,⁽¹³⁾ Эдгээр ТББ нь уул уурхайн салбарын ил тод байдлыг сайжруулах, иргэдийг мэдээллээр хангах болон зөрчил маргааныг шийдвэрлэхэд тодорхой хувь нэмэр оруулсаар ирсэн. БОАЖЯ ННХ-тэй хамтран байгаль орчныг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтран ажиллаж эрх зөрчлөлийн зэрэг тэмцэх, ойжуулах, мод ургамал тарих, ан амьтан хамгаалах зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь КНХ-ыг сайжруулахад төр өөрт дутагдалтай байгаа нөөц болгомогийг иргэний нийгэмтэй хамтран ажиллаж замаар нөхөж буй буй дэвшилт арга хэмжээ юм.

КНХ-ыг хөгжүүлэхэд чадварлаг, хянамтай иргэний нийгмийн байгууллага чухал ач холбогдолтой гэдгийг хөгжингүй орнуудын туршлага харуулдаг. Гэвч Монгол Улсын иргэний нийгмийн идэвхтэй бие даасан оролцоо нь сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд л хөгжиж байгаа бөгөөд төрөөс ТББ-тай зөвлөлдөх, хамтран ажиллах талаарх нэгдмэл үзэл баримтлал, нийтлэг бүтэц, механизм нь хараахан төлөвшөөгүй эхлэлийн түвшинд байна.⁽¹⁴⁾ Нөгөө талаас, ТББ-ын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сайн бэхжээгүй.

Үндэсний хөгжлийн цолц бодлого болон холбогдох бусад хуульд төр шийдвэр гаргах түвшинд иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх үүрэгтэй хэмээн заасан. Энэ мэтээр олон талын харилцан хамтын ажиллагааг дэмжих бодлогыг төрөөс тунхаглан зарлаж ирсэн хэдий ч эдгээрийн хэрэгжилтийг хангах механизмьг төлөвшүүлээгүйн улмаас хамтын ажиллагаа тогтвортой хөгжихгүй байна. Тухайлбал, Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулиар хууль, шийдвэрийн төсөлд иргэн, ТББ-ын саналыг авах тухай заалт тусгасан хэдий ч, тухайн саналыг хууль, шийдвэрийн төсөлд тусгах эсэх нь тухайн хууль, шийдвэрийг санаачлагчийн үзэмжээр шийдвэрлэхээр байгаа бөгөөд төсөлөө цахим хуудсанд 10 хоног тавихаар заасан нь Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан 14 хоногтой мөн зөрж байна.

(10) Daniel Kaufmann, Aart Kraay and Massimo Mastuzzi (2010). "The Worldwide Governance Indicators: A Summary of Methodology, Data and Analytical Issues". World Bank Policy Research Working Paper No. 5430
(11) Transparency International, Corruption Perceptions Index <http://www.transparencymonitor.org/cpi/>
(12) Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнийн тайлан, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, Судалгаа шинжилгээний алба, Улаанбаатар хот 2010.
(13) Өнөөдөр сонин, 2008 оны 9 сарын 3, Балдоржийн нэрэмжит "Эко-танхим". Байгаль орчны дэд сайд Дэлгэрцогт (14) Я. Бямбажав, Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь ТББ-ын оролцоо. Эх сүлн орчин ба институтчилал, ННХ, 2007 он.

Энэ мэтчилэн хэрхэн оролцоог хангах, хангахгүй тохиолдолд хэн, ямар харууллага хүлээхийг нь шийдэж өгөөгүйн улмаас энэ үйл ажиллагаа нь нэр төдий хэрэгжиж байна.

Монгол Улс Үндсэн хууль (1992 он)-иар иргэдийн мэдээлэл авах эрхийг багалгаажуулж өгсөн ч 2011 онд л Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг УИХ-аас баталсан. Тусхуулиар төрийн байгууллагын нийгэд ил тод байх мэдээллийг жагсааж, тухайн мэдээллийг ил тод тавиагүй албан тушаалтантай харууллага тооцохоор зохицуулсан нь сайшаалтай юм.

3.3. КНХ-ын өнөөгийн байдал

КНХ нь Монгол Улсад нэлээд шинэлэг ойлголт бөгөөд эхлэл шатандаа явж байна. КНХ-ын төрийн бодлогын оролцогч талуудад төрийн байгууллага, хувийн хэвшил, ТББ, иргэд ордог. Одоогийн байдлаар төрийн болон төрийн бус оролцогчдын аль аль нь КНХ-ыг чухал ач холбогдолтой гэж үзэж байгаа нь сайшаалтай боловч энэ талаар нэгдсэн ойлголт байхгүй бөгөөд ойлголтууд нь өөр хоорондоо зөрчилдөж байна. КНХ-ын тайлангаас нь үзэхэд компаниуд КНХ-ыг сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх сайн үйлсийн үйл ажиллагаа гэдгээс эхлээд өөрсдийн үйл ажиллагааны нийтэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн өмнө хүлээх харууллага, тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр зэрэг янз бүрийн хүрээнд ойлгож байна.⁽¹⁵⁾ Стандартчилал хэмжигд зүйн газар ISO 26000 стандартыг 2012 оны 1-р сарын 26 ны өдөр MNS ISO 26000:2012 буюу “Нийгмийн харууллагын

Энэхүү хууль хэрхэн хэрэгжихээс иргэд, хуулийн этгээдийн шийдвэр гаргах түвшинд оролцоо оролцоо ихээхэн хамаарна. Үүний зэрэгцээ хууль, захиргааны шийдвэр гаргах үйл явцыг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн актад иргэдийн оролцоо инстигтчилгах нь тулгамдсан асуудал болж байна. Учир нь одоогийн зохицуулалтаар иргэд, хуулийн этгээдийн шийдвэр гаргах шатанд оролцоо оролцоо шийдвэр гаргахчдын санаачлага, хүсэл сонирхол, үзэмжээс ихээхэн хамааралтай хэвээр байсаар байна.

“Удирдамж/Зөвлөмж” нэртэйгээр Монгол Улсын стандартгаар баталсан явдал нь КНХ-ын төрийн бодлогыг тодорхойлоход тун чухал алхам болжээ. Энэхүү стандартыг үндэсний стандарт болгох ажлыг 2011 оны 6-р сараас эхлүүлсэн бөгөөд Стандартчилал хэмжигд зүйн газар (СХЗГ), Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой (МАОЭНХ) хамтран Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам (НХХЯ), Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК), Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МУХААТ), Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ), болон “Энержи Ресурс” компанийг оролцуулан хамтарсан ажлын хэсэг байгуулж ажилласан байна.⁽¹⁶⁾ Хэдийгээр КНХ-ын асуудлаар үндэсний стандарт багтаарсан боловч энэ нь сайн дурын үндсэн дээр хэрэгжих тул энэ талаарх мэдээлэл сурталчилгааг өргөнөөр хийх шаардлагатай юм.



Шигтгээ 1. Компанийн нийгмийн харууллага хэмээх нэр томъёог оновчтой болгох

...КНХ хэмээх орчуулгаас үүдэлтэй компани, хувийн хэвшил л нийгмийн харууллагатай байх ёстой мэт ерөөсөлг ойлголт байгааг цаашид залруулах шаардлагатай. Утга бол “Байгууллагын нийгмийн харууллага” гэж тодорхойлох нь оновчтой юм...

МАОЭНХ, Хөдөлмөр сонинны албаны хүмүүстэй хийсэн ярилцлагаас

Түнчлэн, МУХААТ-аас НҮБ-ийн Даян дэлхийн гэрээ санаачлагыг дэмжин ажиллаж, энэхүү гэрээнд жилээс жилд олон тооны компаниуд нэгдсээр байна. НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (Global Compact), ISO 26000 стандартыг нэвтрүүлж байгаа туршлагаас харахад Монгол Улс КНХ-ын талаарх олон улсын туршлагыг шууд аван хэрэгжүүлж байна. Энэ шинэлэг ойлголтыг нэвтрүүлэх, суралцах шатандаа явж байгаа энэ үед ийнхүү бусдын туршлагыг шууд хуулбарлах нь артагүй юм. Харин цаашид төрөөс КНХ-ын талаарх бодлого боловсруулахдаа КНХ-ыг өөрийн орны эдийн засаг, соёл, бодлогын орчны онцлогийг тусгасан байдлаар тодорхойлох нь зүйтэй.

Шигтгээ 2.

Компанийн Нийгмийн Харууллагын талаарх ойлголт

Номин Холдингс

“Компанийн нийгмийн харууллагын талаар нэгдсэн нэг ойлголт, томъёолол тогтоолгүй байгаа бөгөөд байгууллага бүр өөр өөрийнхөөр ойлгож, хэрэгжүүлдэг. Бид компанийн нийгмийн харууллагыг ойлгохдоо манай үйл ажиллагаа ажилчид, үйлчлүүлэгчид, харилцагчид, улс орон, нийтэм, байгаль орчинд нөлөөлж буй байдал нь зэрэг байх ёстой, мөн компани нийгмийн нэгэн субъект болохын хувьд нийт нийгэмд үрт хугацаанд тогтвортой хөгжихөд тулгарч буй бархшээлийг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах ёстой гэсэн байр суурингаас ойлгож ханддаг.”

Мобиком корпораци

“Компанийн нийгмийн харууллага гэдэг нь аливаа компани үйл ажиллагаагаа хүний эрүүл мэндэд сөрөөр нөлөөлөхгүйгээр, байгаль орчныг бохирдуулахгүй, нийгэмд сөрөг үр дагавар авчрахгүйгээр ил тод, нээлттэй явуулан хамтрагч, түншүүд, өлөн нийт, хэрэглэгч, ажиллагсдынхаа өмнө хүлээх харууллага, чиг хандлага тодорхойлсон хэви хэмжээнүүдийг бизнесийн үйл ажиллагаандаа баримтлан ажиллах замаар нэг зэргээр байгууллагадаа баялгийг бүтээн бий болгож, нөгөө талаар улс орныхоо нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмрээ оруулах үйл явц юм.”

(15) Монголын компаниудын нийгмийн харууллагын тайлан, МУХААТ, 2007
(16) <http://shuudial.bsa.gov.mn/lead/emb/351612> (2012.05.08)

3.3.1. Компанийн нийгмийн харилцааны төрийн бодлого

Төрийн байгууллагууд

Төрийн байгууллагын оролцогчдын хувьд КНХ-ын төрийн бодлогын ач холбогдлыг ойлгож байгаа боловч КНХ-ын талаар нэгдсэн ойлголт, төрийн тусгайлан бодлого, стратеги байхгүй байна. Мөн энэ асуудлыг тухайлан харуулсан төрийн байгууллага байхгүй байна. Олон улсын туршлагаас харахад КНХ өндөр хөгжсөн орнууд энэ талаар төрийн бодлого нь тодорхой бөгөөд харуулсан төрийн байгууллагатай байдаг бол КНХ сул хөгжсөн орнуудад нэгдсэн бодлого ч, харуулсан байгууллага ч байдаггүй.

СХЗГ нь ISO 26000 стандартыг олон улсын түвшинд багтгадаг үйл явцаас эхлэн оролцож, энэхүү стандартыг үндэсний стандартаар батлуулах чиглэлээр МАОЭНХ-той хамтран, бусад талын оролцоог хангах замаар ажилласны дүнд 2012 оны 1-р сард MNS ISO 26000:2012 буюу "Нийгмийн харилцааны удирдамж/Зөвлөмж" нэртэйгээр үндэсний стандарт болгон баталсан явдал нь КНХ-ын төрийн бодлогыг оновчтой тодорхойлоход энэхүү стандартыг үндэс суурь болгож болохоор байна.

Манай улсын тухайд КНХ-ын асуудалд хамаатай төрийн гол байгууллагууд бол УХШХ буюу тус хорооны Хувийн хэвшил, инновацын бодлогын хэлтэс болон КЭҮЗ юм. УХШХ нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг зөв зохистой төлөвлөх зорилготой байгууллага⁽¹⁷⁾ бөгөөд энэ хүрээнд эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбаруудын хөгжлийн бодлогын үйлдвэр ханган, төр болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр ажилладаг.

Манганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд салбарын болон дунд, урт хугацааны бодлогын үйлдвэр хангах үүрэгтэй байгууллага болохын хувьд КНХ-ын бодлогыг харууцан ажиллаж, төрийн байгууллагуудын харилцан үйлдвэр хангах боломжтой. УХШХ MNS ISO 26000:2012 стандартыг зөвлөмж хэлбэрээр нутгалшуулахад манлайлан оролцох эрмэлзэлтэй байгаа нь судалгааны ярилцлагын явцад харагдаж байсан.


Гэвч одоогоор салбаруудын хооронд зохицуулалт хийх, байнгын холбоо харилцаатай ажиллах тал дээр учир дутагдалтай бөгөөд КНХ-ыг тухайлан харууцдаг ажиллах чиг үүрэг нь тодорхой биш байна.

КЭҮЗ нь дөнгөж байгуулагдаад байгаа бөгөөд СЭХ, УХШХ, ТӨХ, МБ, МХБ, КЭХТ, МАОЭНХ, МУХАЛТ, МБХ-ны төлөөлөлтэй байгууллага юм. Үндэсний зөвлөлийн энэхүү олон талын төлөөлөл нь уг байгууллагыг КНХ-ыг цаашид харууцах бол давуу талыг олгож байна. Гэвч дөнгөж байгуулагдаад, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах шатанд байгаа тул КНХ-ыг харууцан ажиллах бүтэц мөн эсэх тал дээр одоогоор дүгнэлт хийх боломжгүй юм. КЭҮЗ нь одоогоор компанийн засаглалыг сайжруулах ажилдаа голлон анхаарч, КНХ-ыг компанийн засаглалыг сайжруулах хүрээнд л хамруулж байна.

Эдгээр байгууллагаас гадна тодорхой үйл ажиллагааны хүрээнд Засгийн газар, СЯ, НХХЯ, ХХААХҮЯ, ЭБЭХЯ, БОАЖЯ, ТЕР, ТЕР, СХЗГ, ЗГТС, ИТХ, Засаг дарга зэрэг байгууллагууд КНХ-ын төрийн оролцогчийн үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах хүрээнд Засгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хороо байгуулагдсан боловч явуулсан үйл ажиллагааны талаар тоймтой мэдээлэл байхгүй байна.

Эдгээр төрийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны хүрээнд л КНХ-ын асуудлыг хамруулдаг бөгөөд үйл ажиллагааны үйлдвэр нь хангадаг нэгдсэн зохицуулалтын газар байхгүйн улмаас тэдгээрийн хооронд үйл ажиллагааны үйлдвэр холбоо маш муу байна.



Шилтгээ 3.

Их Британийн КНХ-ын асуудал харуулсан төрийн оролцоог

Их Британи нь КНХ-ын төрийн бодлого өндөр хөгжсөн орон юм. КНХ-ын бодлоготой бөгөөд Бизнес, Шинэтгэл ба Чадавхийн Газар (БШЧГ) нь уг бодлогыг харууцан ажилладаг. *Бүтэцтэй хөгжилд* хүрэх нэг гол арга хэрэгсэл, нөөц боломж нь КНХ гэж үздэг. КНХ-тай хамбоотой төрийн байгууллагуудын аливаа үйл ажиллагааг энэхүү харуулсан газар нь нэгтгэн зөвчилж, харилцан үйлдвэр хангадаг.

Оролцогч талуудтайгаа харилцан ярилцах, хамтран ажиллах зарчмаар ажилладаг. КНХ-ын талаар тусад нь цахим хуудас ажиллуулдаг бөгөөд КНХ-ын ач холбогдлыг олон нийтэд, ялангуяа аж ахуйн нэгжүүдэд ойлгуулах, мэдлэг олгоход ихээхэн анхаардаг. Түүнчлэн аж ахуйн нэгжүүдийг КНХ-ын үйл ажиллагаатай тайлагнахыг хуулиар шаарддаг. Мөн төрийн худалдан авалтын шалгуурыг КНХ-тай үйлдүүлж өгсөн байдаг. КНХ-ын тайланг БШЧГ бусад төрийн байгууллагуудтай хамтран гаргадаг.

"Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги"-д дурьдсанаар хувийн хэвшлийн хөгжил, үйл ажиллагааг зохицуулах төрийн бодлого, шийдвэрт тэдний санал, санаачлага, зөвлөмжийг тусгах арга механизм төлөвшөөгүй, төрөөс хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээнд хувийн хэвшлийн оролцоо, үүрэг, харууллага бага, төр, хувийн хэвшлийн хооронд мэдээлэл солилцох ил тод байдал бүрдээгүй зэрэг нь хувийн хэвшлийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна гэжээ.

Аливаа компани өөрийн КНХ-ын талаар тодорхой ойлголттой болохын тулд эдгээр олон байгууллагад хандах, тус бүртэй нь харилцах шаардлагатай болж байгаа нь ихээхэн зардал, чирэгдэлтэй байдаг.

(17) http://www.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=22&Itemid=473&lang=en

3.3.2. Компанийн нийгмийн харилцааны төрийн бодлого

Төрийн бус оролцогчид

Монгол Улсад хувийн хэвшил үүсээд ердөө 20-иод жилийн хугацаа өнгөрч байгаа хэдий ч эдийн засагт тэргүүлэх нөлөөтэй салбар болон хөгжсөн юм. Үүнтэй холбоотойгоор КНХ ч Монгол Улсад нэлээд шинэлэг ойлголт бөгөөд сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. Одоогоор КНХ-ын талаар үндэсний хэмжээнд тогтсон нэгдсэн ойлголт байхгүй. Гэвч монголын компаниуд өөр өөрсдийн ойлголтын хүрээнд нийгмийн харилцааны чиглэлээр хэдийнэ олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг болж, энэ чиглэлээр хөрөнгө мөнгө багатай зарцуулж байна. МУХАУТ-аас 2007 онд нийтэлсэн КНХ-ын тайланд 49 компанийн КНХ-ыг хэрэгжүүлэх хүрээнд зарцуулсан гэж мэдээлсэн тодорхой зардлын дүнг түүвэрлэн тооцож үзэхэд л нийт 50 орчим тэрбум төгрөг болсон байна. Энэ хүрээнд ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгаль орчныг хамгаалах, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, спорт, урлагийн чиглэлд ихээхэн анхаарчээ.⁽¹⁸⁾

Зураг 3. КНХ-ыг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө



КНХ-ын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ компаниуд болон ТББ-ууд энэ чиглэлээр төрийн байгууллагатай үр дүнтэй хамтарч ажиллах арга зам эрэлхийлдэг болсон байна.

МАОЭНХ нь СХЭГ-тай хамтран ISO 26000 буюу Компанийн нийгмийн харилцааны стандартыг монгол хэл рүү хөрвүүлж, үүнийг үндэсний стандарт болгох чиглэлээр ажиллаж, энэ онд үндэсний стандарт болгон батлуулсан юм⁽¹⁹⁾. Энэ чиглэлээр талуудыг оролцуулсан хэлэлцүүлгүүд зохион байгуулах, сургалтын модуль боловсруулах зэрэг ажлуудыг харууцан гүйцэтгэжээ.

МУХАУТ-ын дэргэд КНХ-ын зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Жил бүр гишүүн байгууллагуудын КНХ-ын тайланг хүлээн авч, тэдний ирүүлсэн мэдээлэлд үндэслэн шилдэг байгууллагыг тодорхойлдог.

Нөгөө талаас, компаниуд өөрсдийн ойлголтын хүрээнд нэлээд хэмжээний хөрөнгө, нөөцийг КНХ-тай холбоотой гэж үзсэн төрөл бүрийн үйл ажиллагаанд зарцуулж байна. Энэ их хөрөнгө нөөцийг төр КНХ-ын бодлогоороо дамжуулан хамтран ажиллах, харилцан мэдээлэл солилцох замаар Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд залж чиглүүлэх боломжийг ийнхүү алдаж байгаа нь харардаж байна.

КНХ-ын төрийн оролцогч

Гол үүрэг/Хийж ажлууд

Сангийн яам
“Эсгийн газар болон хувийн хэвшлийн хамтарсан зөвлөлдөх хороо”-ны бүрэлдэхүүн, дүрмийг баталж, тус хороог удирдан ажиллах чиг үүрэгтэй.

Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтэс
КНХ-ын асуудлыг чиг үүргийн хувьд харууцдаг гэж өөрсдийгөө тодорхойлсон. Энэ хүрээнд ISO 26000 стандартыг зөвлөмж хэлбэрээр нутагшуулах талаар ажиллахаар төлөвлөж байгаа юм байна.

Төрийн өмчийн хорооны Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессийн газар
Төр, хувийн хэвшлийн түншлэл, концессийн газар нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, энэ чиглэлээр бодлого боловсруулах, тайлан гаргах чиг үүрэгтэй.

Стандартчилал хэмжил зүйн газар
MNS ISO 26000:2012 буюу “Нийгмийн харилцааны удирдамж/Зөвлөмж” нэртэй үндэсний стандартыг баталсан.

Компанийн засаглалыг хөгжүүлэх зорилгын хүрээнд 2011 онд төр, иргэний нийгмийн байгууллагын олон талын оролцоотой байгуулагдсан, КНХ-ын талаар хийхээр төлөвлөсөн тодорхой ажил одоогоор байхгүй.

Хүснэгт 3. КНХ-ын төрийн оролцогч

(18) Энэ тооцоог зөвхөн тайланд тодорхой дурьдсан мөнгөн дүнг буюу мэдээлсэн тоог цуглуулан хийсэн бөгөөд жинхэнэ зарцуулалт нь үүнээс өндөр гарна.
(19) Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБХХ, ҮБ, 2011, 39-р тал

МУХААҮТ-ын КНХ-ын зөвлөлийн хувьд 50 гаруй гишүүнтэй бөгөөд НУБ-ын Даян Дэлхийн гэрээ санаачлагын Монгол дахь албан ёсны сүлжээг хариуцан ажилладаг.

Уг сүлжээнд Монголын 180 гаруй компани нэгдсэн бөгөөд гэрээний зарчмуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг байна.⁽²⁰⁾

Одоогоор КНХ-ын талаар сайн ажилласан компаниудыг шалгаруулах, сайшаах, олонд таниулах ажил ихээхэн хийгдэж байгаа боловч энэ талаар доголдож буй компаниудыг шүүмжлэх, таниулах, шахалт үзүүлэх тал дээр нэгээд хоцрогдолтой байгаа нь харгалдаж байна. Тухайлбал, БНХАУ-ын Цэвэр бүтээгдэхүүнийг дэмжих актын 17-р зүйлд Байгаль орчныг хамгаалах агентлаг нь бохирдуулагч компаниудыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлахаар зохицуулсан.⁽²¹⁾ Тус жагсаалтад олон компани энэ хуулийн 31-р зүйлийн дагуу өөрсдийн буруутай үйл ажиллагааг дэлгэрэнгүйгээр олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээдэг байна.

ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөр, ННФ, АХБ, АНУ-ын ОУХА зэрэг олон улсын байгууллагууд КНХ-ын чиглэлээр нэлээд ажил зохион байгуулж байна. ННФ нь КНХ-ыг хэрэгжүүлэхэд ТББ-ын оролцоог

дэмжих, чадавхжуулах чиглэлээр нэлээд ажил хийдэг.

Харин ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрийн хувьд КНХ-ын чиглэлээр өргөн хүрээнд анхаарч байна. КНХ-ын талаар хоёр ч төрлийн судалгаа хийж, уулзалт семинар зохион байгуулж, оролцогчдыг холбож өгөх тал дээр идэвхтэй ажиллаж байна. Энэхүү КНХ-ын төрийн бодлогыг үнэлэх судалгаа нь ажил ямар түвшинд байгааг үнэлж, улмаар цаашид ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэх юм.

Түүнчлэн, ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрөөс "Өрсөлдөх чадвар ба Компанийн нийгмийн харилцаатай" сэдэвт олон улсын бага хурал зохион байгуулж, хурлаас гарсан саналын дагуу хэд хэдэн үйл ажиллагаа явуулжээ. Мөн уул уурхайн компаниудын КНХ харууцсан ажилтнуудыг чадваржуулах сургалт, уулзалт тогтмол зохион байгуулж, мөн өсвөр үеийнхний дунд нийгмийн харилцааны ойлголт өгөх сургалт, КНХ-ын мэргэжилтнээр хангах, КНХ-ын менежер бэлтгэх сургалт, КНХ-ын талаар олон улсын туршлагаас суралцах танилцах аялал зохион байгуулах зэргээр ажиллаж байна.

КНХ-ын төрийн бус оролцогч

Нэр Гол Урвэг/Хийх ажлууд

MAOЭНХ ISO 26000 буюу Компанийн нийгмийн харилцааны стандартыг монгол хэл рүү хөрвүүлж, үүнийг үндэсний стандартад болгуулах талаар нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, энэ чиглэлээр сургалтын модультай болсон. Мөн Хөдөлмөр, нийгмийн зөвшилцө 3 талт түншлэлийн хүрээнд "Шилдэг ажил олгогч эзэн" шалгаруулах журмыг хүний эрх, хөдөлмөрийн харилцаа, компанийн засаглал, нийгмийн харилцааны үзүүлэлтийг оруулан боловсруулсан. КНХ-ын чиглэлээр бодлогын хэлэлцүүлгүүд, сургалт зохион байгуулдаг, энэ чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажилладаг.

МУХААҮТ НУБ-ын Даян дэлхийн гэрээ санаачлагын хүрээнд Монголын албан ёсны сүлжээг хариуцан ажилладаг. Жил бүр КНХ-тай компаниуд шалгаруулах "Excellence in CSR" шагнал, "Green awards" Ногоон хивсний ёслол, "Green office" хөдөлгөөн, "Компанийн Нийгмийн Харилцааны форум" зохион байгуулж байна. "CSR Mongolia" улирал тутмын электрон сэтгүүл, Монголын компаниудын нийгмийн харилцааны тайланг нэгтгэн гаргадаг.

МУЭ 2010 онд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг үлгэр жишээ хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулсан. Хөдөлмөр сонинтой хамтран "Нийгмийн харилцаатайгаа нийтэд зарлан-2011" уралдааныг зарлаж, дүгнэсэн зэрэг санаачлага байна.

КЭХТ Компанийн засаглалын сургалтын хөтөлбөрт КНХ-ын талаар 3 цагийн хичээлийн хөтөлбөртэй.

Хүснэгэл 4. КНХ-ын төрийн бус оролцогч

3.4. Компанийн нийгмийн харилцааны төрийн бодлого: Баримт бичиг, үйл ажиллагаа

3.4.1. Заавал биелүүлэх хүрээ

КНХ-ыг тусгайлан авч үзсэн хууль тогтоомж одоогоор байхгүй байна. Гэвч олон хуульд КНХ-ын асуудлыг тусгасан бөгөөд байгаль орчин, хөдөлмөрийн эрх зүйн хүрээнд баталсан хуулиудын дийлэнхэд КНХ-ын асуудал ямар нэг хэмжээнд тусчээ.

Мэдээлэх, тайлагнах, үнэлгээ хийх гэх мэт тодорхой үүрэг аж ахуйн нэгжид хүлээлгэсэн заалтууд эдгээр хуульд орсон байна.

Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай жуурь (1996)-иар байгалийн баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах этгээд байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлгээг хийх, нөхөн сэргээх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008)-иар үйлдвэрлэлийн явцад хэрэглэж байгаа химийн хорт ба аюултай бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын талаар тэмдэглэл хөтөлж, мэдээлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаар статистикийн байгууллагад мэдээлэх, ажилтныг үйлдвэртэй, ажил үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах, зардлыг хариуцахыг үүрэг болгосон байна.⁽²²⁾

Түүнчлэн, Нийгмийн даатгалын тухай хууль (1994)-иар ажил олгогчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг тогтоож өгсөн. Ийнхүү, КНХ-ын заавал хэрэгжүүлэх наад захын шаардлагууд хууль тогтоомжид туссан нь сайн талтай ч хэрэгжилт хангалтгүй байна. Жишээ нь, компаниуд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийхдээ нутгийн иргэдийн саналыг тусгах, нутгийн иргэдийн саналыг тусгааргүй бол үнэлгээг буцаахаар хуульчилсан. Гэтэл энэхүү үнэлгээний үнэн зөв, чанартай хийгдсэн эсэхэд хяналт тавих чадавхи БОАЖЯ-д төдийтэн сайн бүрдээгүй бөгөөд үнэлгээг батлахдаа нутгийн иргэдийн саналыг авсан эсэхийг огт харгалзаж үздэггүй байна.⁽²³⁾

КНХ-ын талаар тодорхой эрх зүйн зохицуулалт байхгүй болгох компанийн засаглалт хөгжүүлэх бодлолыг боловсруулж, хэрэгжүүлэхэд төрөөс нэлээд анхаарал хандуулж байгаа нь Компанийн тухай хууль (2011), Компанийн засаглалт хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (ЗГ, 2011 оны 69-р тогтоол), тус хөтөлбөрийн дагуу байгуулагдсан Компанийн засаглалын үндэсний зөвлөл зэрэг санаачлагуудаас харгалдаж байна. КНХ-ыг хэрэгжүүлэх нэг чухал нөхцөл бол яах аргагүй компанийн сайн засаглал юм.

Хувийн хэвшилд хүний эрхийн талаар тодорхой үүрэг хүлээлгэсэн хууль тогтоомж байхгүй болгох иргэд Хүний эрхийн үндэсний комисс /ХЭҮК гэх/-т хандан хувийн хэвшлийн эсрэг гомдол мэдүүлж, шийдвэрлүүлэхээр ХЭҮК-ын тухай хуульд заасан нь хүний эрхийн талаар хувийн хэвшил тодорхой үүрэг хүлээж байгааг харуулж байгаа юм.

Харин Жөндөрийн тэгш байдлын тухай хуулиар (2011) ажил олгогч хүйсээр ялгаварлан гадлуурхахгүй байх, адил хөдөлмөрт адил цалин хөлс олгох, ажилд орж чадаагүй иргэний хүсэлтээр эсрэг хүйсийн хүнийг ажилд авсан үндэслэлээ бичгээр гаргаж өгөх, эрэгтэй эмэгтэй ажиллагсдад адил хандах, хүйсийн тэнцвэртэй байдлын тухай тайлангаа жил бүр сум, дүүргийн Засаг даргад гаргаж өгөх зэрэг үүргийг хүлээсэн байгаа нь энэ чиглэлд гарсан нэлээд шинэлэг зохицуулалт болжээ.⁽²⁴⁾ Эдгээр үүрэг ажил олгогч биелүүлээгүй тохиолдолд ХЭҮК-т гомдол гаргаж шийдвэрлүүлэхээр заасан байна.

Мөн ажил олгогч нь ажлын байран дээрээ ажиглалтад сургалт явуулах, хөдөлмөрийн дотоод журамд гомдол шийдвэрлэх хэм хэмжээ тусгах, хэрвээ энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол ажлын байран дээр ажиглалтын ялгаварлан гадлуурхахгүй төлөө харууцлага хүлээх, гэм хорыг арилгах үүрэг хүлээсэн байдаг. Дээр дурьдсан хуулиар гадна байгаль орчин, хөдөлмөр, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомжуудад КНХ-д холбогдох зохицуулалтууд тусч, хэрэгжүүлээгүй тохиолдолд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, торлох болон захиргааны, эрүүгийн харилцаага хүлээлгэхээр заажээ.

Гэсэн хэдий ч эдгээр хуулийн хэрэгжилт хангалтгүй, КНХ-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн бус байгууллагаас тавих хяналт, чиг үүрэг хэт ерөнхий, хуулийг хэрэгжүүлэх механизм тодорхой биш байгаа зэргээс үүдэн КНХ-ын хүрээнд заавал хэрэгжүүлэх заалтууд үр дүнтэй хэрэгжиж чадахгүй байсаар байна.

Хуулийн нэр	Он	Товч танилцуулга
КНХ-д холбоотой хууль тогтоомж		
Компанийн тухай хууль	2011	Компанийн засаглалын талаар бие даасан бүлэг оруулсан.
Жөндөрийн тэгш байдлын тухай хууль	2011	Жөндөрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ажиглан сонгон шалгаруулах, ажлын байрны сургалт зохион байгуулах, гэм хорыг арилгах гэх мэт тодорхой үүргийг ажил олгогч хүлээсэн.
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008	Ажилтныг эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, химийн хорт ба аюултай бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисын талаар тэмдэглэл хөтөлж, мэдээлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогын талаар статистикийн байгууллагад мэдээлэх, ажилтныг үйлдвэртэй, ажил үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамруулах, зардлыг хариуцах зэрэг үүргийг хувийн хэвшилд хүлээлгэсэн.
Авлигын эсрэг хууль	2006	Аж ахуйн нэгж үйл ажиллагааны ёс зүйн дүрэм баталж, түүнийгээ Датаж мөрдөх үүрэг хүлээсэн.
Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль	2003	Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгч хэрэглэгчийн эрхийг хохирсоон хохирноо баривдуулах, доголдолтой бараа бүтээгдэхүүний талаар мэдээлэх, бараа, бүтээгдэхүүнээ зах зээлээс татаж авах гэх мэт асуудлыг зохицуулсан.

(22) Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008.05.22. 14.1, 14.2 зүйл
(23) Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБХХ, УБ, 2011, 78-р тал
(24) Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011.02.02, 11, 23, 24, 25, 26-р зүйл

Эрүүгийн хууль	2002	Хөдөлмөр, байгаль орчин, авлига, татварын холбоотой гэмт хэрэгт эрүүгийн харууцлага хүлээлгэхээр заасан.
Хөдөлмөрийн тухай хууль	1999	Хөдөлмөрийн гэрээ, контракт, хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, ажиглан, ажил олголчийн нийтлэг эрх, үүрэг, хөдөлмөрийн нөхцөл, маргаан, удирдлага, хяналт зэргийг зохицуулж, харьдцлалыг тусгасан.
Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995	Хувийн хэвшилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, газар орчныг сайжруулах, тохижуулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хянах дотоод хяналтын нэгж байгуулах зэрэг үүргийг хүлээсэн.

Хүснэгт 5. КНХ-д холбоотой хууль тогтоомж

3.4.2. Зөөлөн хууль

Монгол Улс хүний эрхийн 50 орчим гэрээ, конвенцид нэгдэн орсон, үндэс ОУХБ-ын хөдөлмөрийн стандартыг тогтоосон конвенциуд ч багтаж буй.

Монгол Улс ОУХБ-ын тулгуур 8 конвенцид бүгдэд нь нэгдэн орсон тул хөдөлмөрийн стандартгаа олон улсын стандарттай нийцүүлэх үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээж байна. КНХ-ын хүрээнд MNS ISO 26000:2012 буюу “Нийгмийн харьдцлалын удирдамж/Зөвлөмж” үндэсний стандарт нь Монгол Улсын бүх аж ахуйн нэгж байгууллага сайн дурын үндсэн дээр мөрдөж ажиллах гол баримт бичиг болж байна.

MNS ISO 26000:2012 стандартыг эс тооцвол КНХ-ын талаар нэгдсэн эрх зүйн зохицуулалт байхгүй боловч УИХ-ын 2008 оны 12-р тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тодорхой асуудлыг тусгасан гэж үзэж болохоор байна. Тухайлбал, тус бодлогыг хэрэгжүүлэгч тал болох хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүргийг

- ▶ *ажлын байр нэмэгдүүлэхийг эрмэлзэх*
- ▶ *ажлын байрны эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх*
- ▶ *ажилтныгаа мэргэжлийн чадварыг дээшлүүлэх*
- ▶ *нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх*
- ▶ *хууль тогтоомжийд заасан үүрээ биелүүлэх*
- ▶ *байгаль орчноо хамгаалах, түүнд халагуй шинэ технологийг нэвтрүүлэх*
- ▶ *зах зээлд шударгаар өрсөлдөх*
- ▶ *ил тод үйл ажиллагаа явуулах, тайлагнах хэмээн тодорхойлсон.*⁽²⁵⁾



Дээрх үүргийг ISO 26000 стандартын 7 бүрэлдэхүүн хэсэгтэй нэлээд төстэй тодорхойлогдсон гэж үзэж болох юм. Энэхүү бодлогод ЖДҮ-ийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, экспортын үйлдвэрлэл хөгжүүлэх, эрчимжсэн газар тариалан, МАА эрхлэх зэрэг олон чиглэлт үйл ажиллагаанд татварын, зээлийн хөнгөлөлттэй бодлого хэрэгжүүлэх, эдийн засгийн урамшуулал бий болгох, экологийн татвар бий болгох зэрэг КНХ-ыг урамшуулсан олон асуудал туссан. Үндэсний хөгжлийн цогц бодлого нь заавал биелэгдэх баримт бичиг биш хэдий ч ЭГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт баримтлах тэргүүлэх чиглэлийг тус бодлогод үндэслэн тодорхойлох, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл болон төсөв, төрийн мөнгөний бодлогод тусган төлөвлөж, хэрэгжүүлэхээр зохицуулсан. Тус бодлогод КНХ-ыг урамшуулсан, дэмжсэн заалтууд нэлээд туссаны зэрэгцээ зохисгүй хэрэглээг хязгаарлаж, байгаль орчинд сөрөг нөлөө бүхий үйлдвэрлэл, үйлчилгээнд экологийн татвар ногдуулах, хувийн хэвшлийн нийгмийн үрэг, харьдцлалыг дээшлүүлэх гэх мэт стратегийн зорилтууд тодорхойлогджээ.

(25) Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 12-р тогтоол, 3.4-р зүйл

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (УИХ, 2003 оны 41-р тогтоол) хувийн хэвшлийн хүний эрхийн талаар хүлээх үрэг, оролцоог тодорхойлсон. Тухайлбал, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахтай холбоотой заавар, журам стандартыг ажигласнаар хүнлүүдийн хөгжлийг эрхийн сургалтад хамрагдах, шалгалт сорилт өгөх, ажигласнаар зориулан мэдээлэл, сургалт явуулах, хамтын гэрээ, хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод журмыг ажлын байранд ил тод тавих, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх явцад хүн-байгальд үүрчүүлсэн хохирлоо бодитой үнэлж, холбоотой.⁽²⁶⁾

КНХ-д холбогдох санаачлага

Нэр	Он	Товч зорилт
МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого	2009	Хувийн хэвшлийн хөгжүүлэх, хувийн хэвшлийн нийгмийн харуулалтыг дээшлүүлэх чиглэлээр тодорхой зорилтуудыг тусгасан.
MNS ISO 26000:2012 буюу "Нийгмийн харуулалтын удирдамж (Зөвлөмж)"	2012	Компанийн засаглал, хүний эрх, хөдөлмөрийн туршлага, хүрээлэн буй орчин, шударга, ил тод үйл ажиллагаа, хэрэглэгчийн асуудал, иргэдийн оролцоо ба хөгжил хүрээнд мөрдөх сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх баримт бичиг
Хувийн хэвшлийн хөгжүүлэх үндэсний стратеги	2011	Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагааг харилцан ашигтай хөгжүүлэх, ажлын байр, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх зорилготой.
Компанийн засаглалын хөгжлийн хөтөлбөр	2011	Компанийн засаглалыг хөгжүүлэх зорилтуудыг тодорхойлж, энэ ажлыг зохион байгуулах механизмыг бий болгосон.
Хүний эрхийн хангах үндэсний хөтөлбөр	2003	Хувийн хэвшлийн хүний эрхийн талаар хүлээх үүрэг, оролцоог тодорхойлсон.

Хүснэгт 6. КНХ-д холбогдох санаачлага

3.4.3. Санаачлага ба Түншлэл

Төрийн байгууллага, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих бодлогын зорилтууд МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого (УИХ-ын 2009 оны 64-р тогтоол), Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги (ЗГ-ын 2011 оны 36-р тогтоол), Компанийн засаглалын хөгжлийн хөтөлбөр (ЗГ-ын 2011 оны 69-р тогтоол), Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт тус тус тодорхойлогдсон байна. Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг "... дунд болон урт хугацааны хөгжлийн стратеги, бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аргаваа бодлогын баримт бичиг боловсруулах, түүнийг сайжруулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанд төр, хувийн хэвшил хамтран ажиллах, түншлэх үйл ажиллагааг хэлнэ"⁽²⁷⁾, түншлэлийг "... төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн болон дэд бүтцийн салбарын суурь үйлчилгээг гэрээний үндсэн дээр шаардлагатай нөөцийг ашиглан хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, учирч болох эрсдэлийг талууд зохиох хувь хэмжээгээр хүлээх үйл ажиллагааг хэлнэ" хэмээн тодорхойлжээ.

Төр, хувийн хэвшил, ТББ-ын оролцоотой зөвлөл, хороо нь хувийн хэвшлийн хөгжил, компанийн засаглал, хүний эрхийн салбаруудад байгуулагдан ажиллах явдал суулийн жилүүдэд нэмэгдэж байна. Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний зөвлөл бол энэ хүрээнд байгуулагдсан шинэ бүтэц юм. Энэ зөвлөл хэрхэн ажиллахаас компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилт хамаарна.

Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх талаар төрөөс нэлээд арга хэмжээ авч байна. ТӨХ-ны бүтцэд төр хувийн хэвшлийн түншлэл, концессийн газар байгуулсан. Үндэсний хэмжээнд "Хөгжилд хүргэх түншлэл" сэдэвтэй анхны форумьт Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын ивээл дор 2011 оны 12 сард зохион байгуулсан.

Сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн КНХ-ын хүрээнд хамаарах тодорхой асуудлаар КНХ-ын оролцогч талуудын зүгээс санаачлаган ярих байдал нэмэгдэж байна. Тухайлбал, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо жил бүр зохион байгуулдаг Хүний эрхийн чуулганаа 2010 онд "Хувийн хэвшил ба Хүний эрх" сэдвийн хүрээнд зохион байгуулж, тус чуулганд төр, хувийн хэвшил, ТББ-ын 100 гаруй төлөөлөгч оролцсон байна. Мөн КЭХТ-өөс компанийн засаглалын хүрээнд тогтмол форумьт олон талын оролцоотойгоор зохион байгуулж, форумьт ас гарсан санал, санаачлагыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагатай идэвхтэй хамтран ажилладаг.

3.4.4. Урамшууллын бодлого

Байгаль орчин, хөдөлмөр, бизнесийн салбарын нийт 80 орчим хуульд Дүн шинжилгээ хийнээс 30 орчим хуульд КНХ-ын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжин, урамшуулсан зохицуулалт агуулагдаж байна. Хуулиудад ажлын байр нэмэгдүүлсэн, байгаль орчинд зэглэл технологийн нэвтрүүлсэн зэрэг шалгуур хангасан аж ахуйн нэгжид татвар, гааль, зээлийн бодлогоор дэмжих тухай зохицуулалт тусчээ.

Төрөөс КНХ-ыг дэмжиж урамшуулж байгаа дараах чиглэлүүд байна.

- ▶ Ажлын байрыг шинээр бий болгосон, хөгжлийн бэрхшээлтэй, ажил олоход хүндрэлтэй хумуусийг ажлын байраар хангах
- ▶ Ажиллагсад олгосон шалнал, байр, орон сууцны хөлс, унаа, хоол, түлшний үнэ, ЭМД, НД-ын шимтгэлийг татвар ногдох орлогоос хасч тооцох
- ▶ Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, булах үйл ажиллагаа
- ▶ Их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт
- ▶ Дотоодод тарьж урдуулсан үр тариа, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тэжээлийн ургамлын үйлдвэрлэл явуулах
- ▶ ЖДҮ-ийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, үйлдвэрлэн борлуулах
- ▶ Үйлдвэрлэлийн аргаар төхөөрч бэлтгэн, дотоодод борлуулсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, газар тариалан, эрчимжсэн фермер
- ▶ Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, экспортын баримжаагай үйлдвэрлэл эрхлэх
- ▶ Эмзэг бүлгийнхэнд үзүүлсэн хандивыг татвараас чөлөөлөх, хөнгөлөх
- ▶ Байгаль орчны судалгаа, шинжилгээ
- ▶ Хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглах
- ▶ Хилийн зурвас газар эзэмших, олон наст ургамал, жимс жимсгэнэ тариалсан, хөрсний бүтцийг сайжруулах
- ▶ Усыг хамгаалах, зохистой ашиглах, усны орчныг тохижуулах, өөрийн хөрөнгөөр цас, борооны ус хуримтлуулах, нуур, цөөрөм байгуулсан, худал гаргасан, хуучин урлагтын систем, угт цэгийг засч, тохижуулсан, усыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, технологийн процесст ялгарсан усаа шаардлагын хэмжээнд хүртэл цэвэршүүлсэн, дахин ашигласан, байгаль орчин, хүний эрүүл мэндэд ивээлтэй технологи нэвтрүүлсэн
- ▶ Байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд зэглэл, дэвшилт технологи нэвтрүүлэх
- ▶ Бүс нутгийг хөгжүүлэх
- ▶ Ашигт малтмалыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хохирол багатай олборлох

Төрөөс компаниудыг нийгмийн харууллагаатай байх нөдлыг дараах байдлаар урамшуулж байна. Үндэ:

- ▶ Төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх
- ▶ Давуу эрхтэйгээр эзэмшүүлэх, ашигтлуулах
- ▶ Орлогын албан татвар, нэмүү өртгийн албан татвар, гаалийн албан татварыг хөнгөлөх, чөлөөлөх
- ▶ Тогтвортой байдлын гэрээ байгуулах
- ▶ Татварын өршөөл үзүүлэх
- ▶ Бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бодлого
- ▶ Мөнгөн урамшуулал, санхүүгийн дэмжлэг үзүүлэх

- ▶ Зээлийн баглан даалт гаргах
- ▶ КНХ-тай байгаа шалгуур үзүүлэлтийг төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх
- ▶ Ажил үйлчилгээг гүйцэтгүүлэхэд гол шалгуур болгох

Дээр дурдсан хөнгөлөлт, урамшуулал нь компаниуд үйл ажиллагаатаа нийгмийн харууллагаатай явуулахад хөшүүрэг болгох сайн талтай. Гэсэн хэдий ч хууль тогтоомжид байгаа зарим заалт тунхаглалын шинжтэй байсаар байна. Мөн өөр хоорондоо зөрчилдөж байгаа заалт байх жишээтэй. Тухайлбал, 1993 онд УИХ-аас баталсан Гадаадын хөрөнгө орууллагын тухай хуулийн 19-р зүйлд МУ-д 20 сая америк доллар түүнтэй тэнцэх төгрөгөөс доошгүй хөрөнгө оруулагчтай тогтвортой байдлын гэрээ байгуулахаар заасан бол 2009 онд баталсан Ашигт малтмалын тухай хуульд 50 сая америк долларын босго тавьсан байна. Мөн байгалийн баялаг ашигласны төлбөртэй холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт, түүний хувь хэмжээ, үндэслэлийг Засгийн газар болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоохоор заажээ. Гэтэл Татварын ерөнхий газраас баталсан төлбөрийн тайлангийн маягтыг батлахдаа холбогдох хөнгөлөлт, чөлөөлөлтийг тусгаагүй бөгөөд Засгийн газраас зохих төрлийн төлбөрийн хөнгөлөлтийн хувь, хэмжээг тогтоогоогүй.

Зарим хуульд энэхүү хөнгөлөлт, урамшууллын хэмжээ, хэрхэн олгох зэрэг нь тодорхойгүй байна. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд төр, түүний байгууллага, албан тушаалтан нь хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлэн ашиглахыг урамшуулахаар заасан ч урамшууллын систем нь байхгүй.

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжуудад байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохиистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилтэт арга, хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг төрөөс урамшуулах журмыг Засгийн газар тогтоохоор заасан. ЭГ "Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ыг 1998 оны 95 дугаар тогтоолоор баталсан боловч байгаль орчны хууль тогтоомжуудад 1998 оноос хойш олон тооны нэмэлт, өөрчлөлт орсон, зарим хууль шинэчлэн батлагдсан, түүнчлэн уул уурхайн салбар 2000 оноос хойш эрчимтэй хөгжсөн зэрэгтэй холбон авч үзвэл хуулийг дагаж гарах дүрэм журмын өөрчлөлт нь шинэчлэгдэн гарсан хуулиудыг гүйцэхгүй байгаа сул тал ажиглагдаж байна.

Энэ мэтчилэн байгаль орчны чиглэлийн хуулиудад төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллагаас байгальд зэглэл, нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагаа, хор хөнөөл багатай технологи ашиглалтыг дэмжих, урамшуулах таллаар тодорхой тооны заалтууд тусгагдсан байгаа ч хэрхэн хэрэгжүүлэх механизм байхгүй байх нь түгээмэл байна. Төрөөс КНХ-ыг дэмжин, урамшуулсан тодорхой бодлоготой байх нь тогтвортой хөгжил, хүний хөгжлийг дэмжихэд чухал түлхэц болно. Гэвч эдгээр бодлого нь "шүдгүй" буюу хэрэгжүүлэх механизм, арга хэлбэр тодорхойгүй гараад байвал тавьсан зорилтуудаа биелүүлэх боломж нь хязгаарлагдах юм.

Дээр дурдсан урамшуулал дэмжлэгээс гадна төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, худалдан авалтад аж ахуйн нэгжид тавих гол шалгуурыг КНХ-тай холбон авч үзэх шаардлагатай. Англи, БНХАУ зэрэг бүсэд улсад төсвийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалт, худалдан авах үйл ажиллагаанд оролцох компаниудад КНХ-д хамарах тодорхой шалгуурыг хангасан байхыг шаарддаг зохицуулалт байна. Энэ талаар огт бодлого байхгүй гэж үзэхээргүй байна.



Тухайлбал, Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн 1.1.6.9-д төсвийн санхүүжилт бүхий худалдаа, ажил үйлчилгээний сонгон шалгаруулалтад оролцох ААН шалгаруулахдаа хүний эрхийг хангаж буй байдал, зөрчил, түүнийг зааруулсан, хохирлыг нөхөн төлсөн байдлыг шалгуур болгох тухай заасан. Гэвч өнөөг хүртэл энэ заалтыг хэрэгжүүлэх бодитой ажил хийгдээгүй байна.⁽²⁸⁾

Төрийн байгууллагын зүгээс авч хэрэгжүүлж байгаа зарим үйл ажиллагаа КНХ-ын зарим үзүүлэлтийг шалгуур үзүүлэлт болгож байна. Тухайлбал, Татварын ерөнхий газрын даргын 2012 оны 234 тоот тушаалаар батлагдсан “Шилдэг татвар төлөгчийг шалгаруулж, урамшуулах журам”-ын 2.1.10 өндөр болон дэвшилт технологий, инновацы үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, 2.1.11 байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн хэрэгжүүлсэн байх зэрэг шалгуурыг шилдэг татвар төлөгчийг шалгаруулахад нэмэлт үзүүлэлт байхаар тусгасан.

Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт шилдэг бизнес эрхлэгчдийг шалгаруулахдаа хүний эрхийн холбогдолтой шалгуурыг нэг гол үзүүлэлт болгохоор заасан. МАОЭНХ нь Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт түншлэлийн хүрээнд “Шилдэг ажил олгогч эзэн” шалгаруулах журмыг хүний эрх, хөдөлмөрийн харилцаа, компанийн засаглал, нийгмийн харууллагын үзүүлэлтийг оруулан боловсруулсан нь хөтөлбөрийн заалтыг хэрэгжүүлэхэд нэг алхам болжээ. Энэ мэтчилэн төр, ТББ дээр тодорхой бодлого, санаачилгууд бий болсон байгаа ч өөр хоорондоо уялдаа, холбоогүй, харилцан мэдээлэл, туршлага солилцох тогтмол харилцаа холбоо байхгүй зэрэг нь тус бодлогын үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

3.4.5. Мэдлэг олгох үйл явц

Судалгааны ажлын явцад КНХ-ын асуудалд шууд хамаарал бүхий гэж үзсэн 3 яам, 2 төрийн байгууллага (БОАЖЯ, ЭБЭХЯ, НХХЯ, Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо)-ын цахим хуудсанд судалгаа хийж үзлээ. Эдгээр байгууллагын цахим хуудсанд КНХ-ын асуудлаар ямар нэг мэдээлэл байхгүй байна.

Төрийн байгууллагаас гадна хувийн хэвшил, ТББ-ын цахим хуудсанд орж КНХ-ын талаар олон нийтэд хэрхэн мэдээлэл түгээж байгаа байдалд дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд МУХААҮТ, МАОЭНХ, КЗҮТ, МБХ, ХУУ, МҮЭХ зэрэг ТББ, Эрдэнэтийн УЕБУ, Номин холдинг ХХК, Хас банк, МАК, Мобиком, Говь ХК, Оюу толгой зэрэг хувийн компанийдын цахим хуудсыг судлав.

КНХ-ын чиглэлээр ажилладаг ТББ-уудын цахим хуудсанд КНХ-ын талаар тусдаа мэдээлэл, хуудас байхгүй байна. МУХААҮТ нь КНХ-ын талаар улирал тутмын цахим сэтгүүл гаргадаг, КНХ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр компаниудын хийсэн ажлын тайланг нийтэлж байгаа зэрэг нь мэдлэг олгох үйл явцад оруулж буй томоохон хувь нэмэр юм.⁽²⁹⁾ КНХ-ын чиглэлээр МАОЭНХ сургалтын модультай бөгөөд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж байгаа, КЗХТ нь КНХ-ын модуль агуулсан сургалтын хөтөлбөртэй байна.

КНХ-ын талаар тусгайлсан тодорхойлолт, мэдээлэл оруулаагүй хэдий ч энэ хүрээнд зохион байгуулж буй үйл ажиллагааны талаар мэдээллийг хувийн хэвшилүүд цахим хуудсанддаа тусгах нь нийтлэг ажиллагдсан.

Энэ хүрээнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ногоон байгууламжийг шинээр бий болгох, хүүхдийн уралдаан тэмцээн зохион байгуулах, спорт, урлагийн арга хэмжээг дэмжих, эрүүл мэндийн цогцолбор байгуулах, гадаад, дотоодын их дээд сургуульд суралцагчдад тэтгэлэг олгох, сургалтын зардлыг хариуцах, ажлын байраар хангах зэргээр ажиллаж байгаагаа компаниуд мэдээлэлдээ дурьдсан байна. Эндээс дүгнэхэд КНХ-ыг сайн үйлсийн үйл ажиллагаагаар л хязгаарлаж ойлгодог хандлага тэргүүлэгч компаниудын хувьд өөрчлөгдөж байгааг харуулж байна.

Сүүлийн жилүүдэд КНХ-ын чиглэлээр зарим санал, санаачилгууд өрнөж байгаа бөгөөд энэ хүрээнд зарим хэвлэмэл материалууд гарч байгаа нь сайшаалтай. Тухайлбал, ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөрөөс “Компанийн нийгмийн харууллага” хурлын эмхтгэл, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хорооноос зохион байгуулсан “Хүний эрх ба бизнес” чуулганы үеэр НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн хууль зүйн үйлчилгээний хүртээмж ба Хүний эрх төслөөс НҮБ-ын Даян дэлхийн тэрээ, НҮБ-ын Үндэстэн дамнасан корпорацы, хувийн зөвшлийн хүний эрхийн асуудлаар хууль зурьт харууллагын хэм хэмжээ хэмээх 2 баримт бичгийг багтаасан мэдээллийн хуудсыг гаргажээ. Мөн МҮЭ, Хөдөлмөр сонин хамтран “Нийгмийн харууллагайгаа нийтэд мэдээлэе-2011” аяныг зохион байгуулсан нь иргэд, аж ахуйн нэгжид КНХ-ын талаар тодорхой мэдээлэл өгсөн байна.

КНХ-ын талаар мэдлэг олгох үйл явц нь уялдаа холбоогүйгээр явагдаж байна. Монгол Улс КНХ-ын талаар үндэсний стандартыг баталсан ч энэ чиглэлээр баримтлах бодлогоо тодорхойлж чадаагүй, харуусан төрийн байгууллага байхгүй байгаа нь үүнд нөлөөлж байна.

4 ДҮГНЭЛТ



КНХ-ын талаар баримтлах төрийн нэгдсэн бодлого байхгүй, энэ асуудлыг ихээхэн ялгавартай байдлаар тайлбарлах нь түгээмэл байна. Зарим бүлгүүд КНХ бол компаниудын зүгээс сайн дурын үндсэндээр хэрэгжих үйл ажиллагаа тул төрорлоцох шаардлагатай хэмээн үзэж байхад, зарим хэсэг нь хууль тогтоомжоор заасан наад захын жишиг стандартыг хэрэгжүүлэх нь КНХ гэж үзэж байх жишээтэй. Гэтэл КНХ бол сайн үйлсийн үйл ажиллагаа юм гэх хэсэг ч байна. Энэ онд Монгол Улс MNS ISO 26000:2012 буюу “Нийгмийн харуулцалтын удирдамж “Зөвлөмж” үндэсний стандарттай болсон явдал энэ хүрээнд гарсан томоохон ахц болсон. Үндэсний стандартаа баталсан нь сайшаалтай бөгөөд цаашид стандартыг холбогдох талууд, олон нийтэд танилцуулах ажлыг эрчимтэй явуулах шаардлагатай юм.

Монгол Улсын төрийн бодлого нь хөгжлийн эхэн шатанд байгаа хэмээн үзэхээр байна. Хэдийгээр хууль тогтоомжид КНХ-ын талаар наад захын стандартыг мөрдүүлэхээс эхлүүлэн ажлын байр нэмэгдүүлэх, дэвшилт технологий нэвтрүүлэх, байгаль орчинд хоргүй арга техник ашиглах зэрэг үйл ажиллагааг урамшуулан дэмжих бодлого туссан ч хуулийн хэрэгжилт хангалтгүй, зарим заалтыг хэрхэн хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байгаа зэргийн улмаас тодорхой үр дүнд хүрч чадахгүй байна. Энэ нь КНХ-ын талаар нэгдсэн ойлголт, тодорхойлолт бий болоогүй, тухайн асуудлыг нэгтгэн харууцдаг төрийн байгууллага байхгүй зэргээс шалтгаалж байж болох юм. Мөн төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн санаачлагатайгаар зарим нэг дэвшилтэй санаа хууль тогтоомжид тусдаг боловч үүнийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх асуудлыг орхигдуулдаг.

КНХ-ын талаар төрийн бус байгууллага, хувийн хэвшил илүү санаачлага гарган ажиллаж байгаа бөгөөд МУХАУТ, МАОЭНХ зэрэг байгууллага тус салбарт манлайлан ажиллаж байна. Монгол Улсын КНХ-ын талаарх төрийн бодлогод НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд тулгуурласан МУХАУТ, ISO 26000 стандартад тулгуурласан МАОЭНХ-ны үзүүлэх нөлөө илүүтэй ажиглагдаж байна. Мөн түүнчлэн ГОУХАН-ийн ЭТИС хөтөлбөр, АНУ-ын СУХА зэрэг байгууллага КНХ-ын чиглэлээр тодорхой санаачлага гарган ажиллаж байна.

Монгол Улсад баримталж буй КНХ-ын талаарх бодлого нь олон улсын жишиг стандарт, үндэстэн дамнасан корпорациудын импортолосон бодлогод түшиглэн хөгжиж байгаа бөгөөд манай улсын эдийн засаг, нийтэм, соёлын онцлогийг хангалттай тусгаатай хэвээр байна. Нөгөө талаас компаниуд КНХ-ыг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой хөрөнгө зарж байгаа болохыг МУХАУТ-ын 2007 онд хэвлүүлсэн Монголын компаниудын нийгмийн харуулцалтын тайлангаас олж үзэх боломжтой.

Тиймээс компаниудын КНХ хэрэгжүүлэх хүрээнд зарцуулж байгаа хөрөнгийг төр стратегий, төлөвлөгөөтэйгээр тогтвортой хөгжлийн зорилтлоо чиглүүлэх болгомжоо алдаж болохгүй. Энэ бүхнээс дүгнэж үзэхэд Монгол Улс КНХ-ын талаар төрийн бодлогыг оновчтой тодорхойлох, хариуцсан төрийн байгууллагыг тогтоох, салбар дундын тэр дундаа төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлага байгааг батлан харуулж байна.

Сүүлийн жилүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, компанийн засаглалыг хөгжүүлэх талаар төрөөс анхаарч хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үндэсний хөтөлбөрийг батлан гаргах зэргээр ажиглаж байгаа нь сайшаалтай.

Ялангуяа, компанийн засаглалыг хөгжүүлэх талаар хуульд тодорхой бүлэг оруулаад зогсохгүй үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх зөвлөлийг холбогдох талуудын оролцоотой байуулсан байна. Энэ зөвлөлийн бүтцийг харахад олон талуудыг оролцуулсан явдал нь уг асуудлыг салбар дундын асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн явдал юм. КНХ-ын асуудал бол үүний нэг адил салбар хоорондын хамтын ажиллагаа, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг оролцоо шаардлагатай салбар болгохыг хүлээн зөвшөөрч, үүнд нийцүүлсэн бодлого, хэрэгжүүлэх механизм, хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Одоогийн байдлаар КНХ-ын асуудлыг өөрийн харьяалах хүрээний асуудал хэмээн УХШХ-ны Шинэтгэлийн бодлогын газрын Хувийн хэвшил, инновацийн бодлогын хэлтсийнхэн үзэж байгаа бол Компанийн засаглалын үндэсний зөвлөл нь зарим талаар КНХ-ын асуудал өөрсдийнх нь хамаарах асуудал хэмээн үзсэн. Гэсэн хэдий ч энэ 2 байгууллагад КНХ-ын талаар үүрэг хүлээлгэсэн эрх зүйн баримт бичиг байхгүй тул цаашид энэ асуудлыг тогтвортойгоор авч үзэх эсэх нь тухайн албан тушаалыг хашиж байгаа хувь хүмүүсээс ихээхэн хамаарахаар байна.

КНХ-ын талаар харууцсан төрийн байгууллага байхгүй тул олон нийт, тодорхой зорилтот бүлгийг чадваржуулах, мэдлэгжүүлэх үйл ажиллагаа төрийн оролцоогүй явагдахад хүрч байна. МУХАУТ, МАОЭНХ, КЭХТ зэрэг байгууллага нь КНХ-ын асуудлаар өөр өөрсдийн баримталсан бодлогын хүрээнд тодорхой сургалтын хөтөлбөртэй бөгөөд энэ нь ихэвчлэн компаниудад чиглэдэг. Гэтэл иргэд, хэрэглэгчид, иргэний нийгмийн байгууллагад чиглэсэн энэ талын мэдлэг олгох сургалт, мэдээллийн үйл ажиллагаа үгүйтэгдэж байна. Учир нь КНХ-тай байх нь илүү зардал гэхээс илүүтэй боломж, тогтвортой хөгжилд хүрэх гол арга зам болгохыг аль аль бүлгүүдэд хүргэх хэрэгтэй юм. Нөгөө талаас КНХ бол зөвхөн төр, компаниудад л хамаарах асуудал биш бөгөөд иргэд, төрийн бус байгууллага, хэрэглэгчдийн мэдлэг, тэдний хяналт, оролцоо чухал ач холбогдолтой.

Бодлогын зөвлөмж

5



1. КНХ-ын талаар тусгайлсан төрийн бодлогыг боловсруулах
КНХ-ын төрийн бодлогыг боловсруулснаар тухайн асуудлаар нийгэмд нэгдсэн ойлголт үнэлэмжийг бий болгох ач холбогдолтой. Уг бодлогын хүрээнд КНХ-ыг тодорхойлохдоо бүх талын оролцоог хангах, КНХ-ын талаарх олон улсын туршлага, сургажийг судалж, өөрийн орны эдийн засаг, нийгэм, соёлын онцлогийг тусгах шаардлагатай юм. 2012 онд багталсан MNS ISO 26000:2012 буюу “Нийгмийн харууллагын удирдамж /Зөвлөмж” үндэсний стандартад туссан КНХ-ын бүрэлдэхүүн хэсгийг төрийн бодлого, шийдвэр боловсруулахдаа үндэслэл болгох болгомжтой.

2. MNS ISO 26000:2012 буюу “Нийгмийн харууллагын удирдамж /Зөвлөмж” үндэсний стандартыг сурталчлан таниулах

Тус стандартад нь багтлагдаад удаагүй байгаа тул тун явцуу хүрээнд л стандартын талаар мэдээлэлтэй байна. Тиймээс энэхүү зөвлөмж стандартыг хэрэгжүүлэх хүрээг өргөжүүлэх үүднээс аж ахуйн нэгж байгууллага, иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг өргөн хүрээнд явуулах шаардлагатай байна.

3. КНХ-ын асуудал харуулсан төрийн байгууллагын бий болгох

Түүнчлэн бодлого хэрэгжүүлэгч харуулсан байгууллагыг тодорхойлж, КНХ-ын талаар хүлээсэн үүрэг хэрэгжүүлэх хүний нөөцийн болон санхүүгийн чадавхийг бүрдүүлэх нь зүйтэй.

Уг байгууллага нь КНХ-ын хүрээнд төрөөс хэрэгжүүлж байгаа болон цаашид авч хэрэгжүүлэх бодлогын уялдаа холбоог хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой. Ингэснээр КНХ-д хамаарах асуудал олон хууль тогтоомж, захиргааны шийдвэрүүдэд туссан ч хэрэгждэггүй, эсвэл өөр хоорондоо зөрчилддөг, давхцдаг, зохицуулалтгүй үлддэг зэрэг оноогийн эрх зүйн зохицуулалтад байгаа алдаа дутагдлыг шийдвэрлэхэд чухал түлхэц болгох болгомжтой. Тус байгууллага нь төрийн байгууллагын уялдаа, харилцаа холбоог хангахын зэрэгцээ бүхий л оролцогч талуудыг мэдээллээр тогтмол хангах, сургалт болон хэлэлцүүлэг, үзлэлтүүд зохион байгуулах зэрэг чиг үүргийг хүлээнэ.

4. КНХ-ын асуудлаар олон нийтэд мэдээлэл хүргэх арга зам
уудыг бий болгох

Судалгааны явцад цахим хуудсандаа КНХ-ын асуудал, энэ хүрээний төрийн зохицуулалтын талаар мэдээлэл багтаасан төрийн байгууллага байсангүй. Гэтэл КНХ-ын бодлогыг бэхжүүлэх гол арга зам бол оролцогчдыг холбоосон сүлжээ бий болгох, мэдээлэл солилцох явдал юм. Үүнийг бий болгох хялбар, зардал багатай арга зам нь энэ чиглэлээр цахим хуудас ажиллуулах болохыг бусад улс орны туршлага харуулж байна.⁽³⁰⁾ Үүний зэрэгцээ КНХ-ын чиглэлээр төрөөс баримталж байгаа бодлогыг нэгтгэн, хялбаршуулан тайлбарлаасан гарын авлагыг бэлтгэж

(30) CSR Navigator. Public Policies in Africa, the Americas, Asia and Europe. GTZ and Bertelsman Stiftung, 2007, pp. 152

цахим болон цаасан хэлбэрээр түгээх нь КНХ-ыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшил, хэрэгжилтэд хяналт тавьж байгаа ТББ, иргэдэд чухал ач холбогдолтой юм. Мөн КНХ-ын бодлогоо тодорхойлоход компаниудад гарын авлага болж, энэ чиглэлийн судалгаа шинжилгээ хийх тэдний зардлыг бууруулах боломжтой. Дээрх арга замуудаар мэдээллийг түгээх нь КНХ-ын талаарх төрийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд түлхэц болно.

5. Хууль тогтоомж, эрх зүйн актад КНХ-ын талаар туссан зохицуулалтуудын хэрэгжилтийг судлах

Энэхүү судалгаанаас харвал КНХ-д хамаарал бүхий олон чухал заалтууд хууль тогтоомж, үндэсний хөтөлбөр, стратегийн баримт бичгүүдэд туссан боловч хэрэгжилтийн тал дээр чир дутагдалтай байж болгохоор харагдаж байна. Иймд, тус зохицуулалтуудын практикт хэрэгжиж буй байдлыг хэрэгжүүлж байгаа механизм, тус бодлогод хамаарах салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн үзэл бодол, үнэлгээг авах замаар судалж үзэх нь КНХ-ын төрийн бодлогыг цаашид оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал арга хэмжээ болгохоор байна.

6. КНХ-ын хүрээнд заавал биелүүлэх үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаар ил тод мэдээлдэг байх

КНХ-ын асуудал харуцсан төрийн байгууллага нь компаниудын КНХ асуудлаар заавал биелүүлэх үүргээ хэрхэн биелүүлсэн талаарх тайланг холбогдох төрийн байгууллагуудаас гаргуулан авч нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай. Ингэснээр КНХ-ын талаар хүлээсэн наад захын үүргээ хэрэгжүүлдэггүй компаниудын талаар олон нийтэд мэдээлэл хүрч, улмаар тус компаниудыг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх хөшүүрэг болгох боломжтой. Энэ тал дээр БНХАУ-ын зохицуулалтын туршлагыг үзэж болгох юм.

7. Төсвийн хөрөнгөөр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг компанийн нийгмийн харууллагатай уялдуулах

Төсвийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаанд оролцох компаниудыг сонгон шалгаруулахдаа тогтвортой хөгжил, экологийн хүрээнд шалгуур тавьдаг олон улсын туршлага түгээмэл байна. Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт энэ чиглэлээр тодорхой зорилт давшуулсан боловч хөтөлбөр хэрэгжээд 8 жил болгох хугацаанд тус зорилт хэрэгжээгүй, энэ чиглэлээр тодорхой алхам хийгдээгүй байна. Тиймээс энэ туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх нь КНХ-ыг сайжруулах нэгэн хөшүүрэг болгох боломжтой.

8. КНХ-ын асуудалд иргэний нийгмийн байгууллага, тэр дундаа ТББ-ын идэвхтэй оролцоог дэмжих

ТББ-ын КНХ-ын талаарх мэдлэг, чадварыг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ, мониторинг хийх төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх зэрэг ажлыг цаашид зохион байгуулах нь зүйтэй.

9. Тэр хувийн хэвшлийн түншлэлийг ашиглан нийгмийн үйлчилгээ, нийгмийн халамжийн тодорхой хэсгийг шийдвэг болгох

МҮХААҮТ-аас 2007 онд КНХ-ын тайланг гаргасан бөгөөд тус тайланд 49 компанийн мэдээлэл багтсан байсан бөгөөд эдгээр компани КНХ-ын хүрээнд ойролцоогоор 50 тэрбум төгрөгийг байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, спорт, урлаг, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэх зэрэг чиглэлээр зарцуулсан байсан. Энэ нь төрөөс КНХ-ын бодлогын хүрээнд хамтран ажиллах замаар компаниудын хөрөнгө нөөцийг бодлоготойгоор Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд чиглүүлэх боломж байгааг тод харуулж байгаа юм. Тиймээс нийгмийн үйлчилгээ, нийгмийн халамжийн зардлын ачааллын тодорхой хэсгийг хувийн хэвшилтэй түншлэлийн замаар шийдвэрлэх боломжийг хайх шаардлагатай.

Хавсралт 1. КНХ-ын хөгжлийн түвшинг тодорхойлох шалгуурууд

Монгол		Англи	
1. ЧАДАВХИ			
КНХ-ын асуудлыг тухайлан харуулсан хүч/ газар засгийн газрын (төрийн бүтцэд) дотор бий юу?	Үгүй, Тухайлан харуулсан байгууллага/хүн байхгүй, Гэвч КЗ-ын хүрээнд УХШХ, КЗУТ энэ асуудлыг харуулдаг.	Тийм. Бизнес, Шингэтэл ба Чадавхийн Газар ⁽³¹⁾ (БШЦГ) нь КНХ-ын бодлогыг харуулсан байгууллага юм. Мөн Олон улсын хөгжлийн газар, Гадаад харилцааны яам нь КНХ-ыг ядуурлыг бууруулах болон хүний эрхийг хамгаалах нэг стратегиа болгодог.	
Энэ харуулсан газар/хүн нь тодорхой заасан зорилго, үүрэгтэй юу?	Үгүй	Тийм. БШЦГ нь компанийн харууллагыг талаарх төрийн бодлогыг удирдах, зохицуулах/ тохируулах замаар төрийн тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих удирдах/зохицуулах Мэргэжлийн үйлчилгээ Зарим бүтээгдэхүүний байгальд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, байгаль орчны төрийн зохицуулалтыг хянах	
Энэхүү харуулсан газар/хүн нь КНХ-ын талаарх аливаа асуудлыг шийдвэрлэх, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх чадвартай юу?	Үгүй	Тийм. БШЦГ нь байгууллагын манлайлах, стратегийн болон гүйцэтгэлийн чадавхийн үнэлгээ хийдэг бөгөөд одоогийн чадавхиа шаргал ногоон буюу дутагдалтай талаа бүрэн илрүүлж, сайжруулах ажил хийж байгаа гэсэн үнэлгээ авсан байна. ⁽³²⁾	
2. СТРАТЕГИЙН ХӨГЖЛИЙН ТҮВШИН			
Тийм. Мянгань хөгжлийн зорилтод суурилсан хөгжлийн цогц бодлогын хүрээнд аж ахуйн нэгжүүдийн хүлээх үүргийг зааж өгсөн. Түүнчлэн компанийн засаглалыг хөгжүүлэх болон бусад асуудлын хүрээнд КНХ-ыг авч үздэг.	Тийм. Их Британийн тогтвортой хөгжлийн стратеги, олон улсын түвшинд ядуурлыг бууруулах, хүний эрхийг дээдлэх зэрэг бодлогын хүрээнд компанийн харууллага, зэрэг хувь намрийг хамгийн их болгох хүрээнд КНХ-ыг авч үздэг.		

Төр КНХ-ын талаар тусдаа стратегитай	Үгүй	Тийм. Төр компанийн харууллагын талаар тусдаа стратегитай: эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин болон ажил эрхлэлтийн тал дээр тавигддаг наад захын шаардлагыг хангахын зэрэгцээ илүү өргөн хүрээтэй харилцаатай үйл хөдлөлийг дэмжих, урамшуулах. ⁽³³⁾
КНХ-ын стратеги нь тодорхой заасан бодлогын зорилгууд, авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс бүрддэг	Үгүй	Тийм. КНХ-ын талаар төр өөрийн аясын харааг тодорхойлж, түүнд хүрэх арга хэмжээнүүдээ тодорхойлсон. КНХ-ын стратеги нь тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд шууд хамаардаг.

3. ЗОХИЦУУЛАГТЫН ГАЗАР БИЙ ЭСЭХ

КНХ нь өргөн хүрээтэй сэдэв гэж ойлгогддог бөгөөд янз бүрийн намдууд/төрийн байгууллага энэ асуудлыг харуулдаг уу?	Тийм. Одоогийн байдалаар төрийн байгууллагуудын хооронд КНХ-ын асуудлыг зохицуулдаг нэгдсэн зохицуулалтын газар байхгүй байна. Төрийн байгууллагууд өөрсдийн харуулсан салбарын хүрээнд тус тусдаа КНХ-тай холбоотой асуудлыг хамарч зохицуулдаг.	Тийм. БШЦГ нь компанийн харууллагын талаар төрийн байгууллагуудыг хооронд нь тохируулах/зохицуулж, тэдгээрийн КНХ-тай хамаатай асуудлыг зангидаг.
КНХ-аар ажлууд хийдэг төрийн байгууллагууд нь хоорондоо холбоотой ажилладаг	Үгүй	Тийм. БШЦГ нь КНХ-ын чиглэлээр идэвхтэй хамтын ажиллагааны сүлжээтэй бөгөөд нэгдсэн платформтой, хоорондоо тогтмол уулздаг
КНХ-аар ажлууд хийдэг төрийн байгууллагууд идэвхтэй хамтын сүлжээний нэг хэсэг бөгөөд нэгдсэн платформтой, хоорондоо тогтмол уулздаг	Үгүй	Тийм. БШЦГ нь КНХ-ын чиглэлээр идэвхтэй хамтын ажиллагааны сүлжээтэй бөгөөд нэгдсэн байгууллагуудтай түншлэн ажилладаг.

4. ОРОЛЦОГЧДЫГ ХОЛБОХ

<p>Төрийн зүгээс КНХ-ын талуудын оролцооны ач холбогдлыг ойлгоосон уу?</p>	<p>Тийм. Талуудыг КНХ-г аль болох өргөнөөр оролцуулах нь чухал болохыг төрийн байгууллагууд ямар нэг байдлаар ойлгож хүлээн авч байна. Тухайлбал, төр хувийн хэвшлийн туншлагийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг гаргасан.⁽³⁴⁾</p>	<p>Тийм. КНХ-ын боллого нь бүхэлдээ хамтын ажиллагаа, харилцан санал солилцох зарчим дээр суурилсан. Төр хувийн хэвшлийн туншлагийг дэмжиж, идэвхтэй оролцдог.</p>
--	---	--

<p>Оролцогч талууд нь КНХ-ын сэдвээр мэдээлэл авдаг</p>	<p>Үгүй</p>	<p>Тийм. Төрөөс оролцогч талуудад КНХ-ын төрийн боллогын талаар тогтмол мэдээлэл хангадаг. КНХ-ын талаар компанийн харилцааны тайлан БШЦГ-ээс гаргадаг. Түүнчлэн КНХ-ын талаар тусгай цахим хуудастай.</p>
---	-------------	--

<p>Оролцогчид нь тогтмол уулзалдаж, гарсан үр дүн нь улс төрд тусгагчаа олж байдаг</p>	<p>Үгүй</p>	<p>Тийм. БШЦГ-ийн бизнесийн секторын нэгжүүд нь салбарын тэргүүлэгч, компаниудтай шууд харилцаатай байж, тэдний сонирхлыг болгогод тусгадаг.</p>
--	-------------	--

5. ХИЙГДЭЖ БҮИ АЖЛУУД

<p>Төрийн зүгээс КНХ-ын мэдэгдэхүйц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн үү?</p>	<p>Тийм. Хууль тогтоомжид КНХ-д хамаарал бүхий заавал хэрэгжүүлэх, хэрэгжүүлэхийг дэмжиж, урамшуулсан тодорхой заалтууд тусгагдсан байна. Түүнчлэн төрөөс КНХ-ыг урамшуулах, дэмжих бодлогын хүрээнд олон төрлийн дэмжлэг, урамшууллыг үзүүлэхээр хуульд тусгасан байна.</p>	<p>Тийм. Их Британийн аж ахуйн нэгжүүд нь компанийн хуулиар КНХ-тай холбоотой ажил хийсэн эсэх болон хэрхэн хийсэн талаар заавал тайлангах үүрэгтэй. Мөн тэтгэрийн сангууд КНХ-тай холбоотой асуудлаар тайлангах үүргийг хуулиар хүлээсэн. Түүнчлэн Их Британийн ЗГ худалдан авалтын шалгуур үзүүлэлтүүдийг КНХ-тай уялдуулж өгсөн. Түүнчлэн, аж ахуйн нэгжүүдийг КНХ-аар нь шалгаруулах, эрэмбэлэх, болон шууд бус урамшууллаар дэмжих зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p>
---	--	---

<p>Хийгдэж буй ажлуудын жагсаалт нь өгөгдлийн хүчин зүйлс болон улс төрийн гол зорилгуудтай тохирч байгаа</p>	<p>Үгүй</p>	<p>Тийм. Их Британийн ЗГ КНХ-ыг тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэх арга хэрэгсэл, нөөц боломж болгоход чиглэсэн боллого хэрэгжүүлж байгаа нь улс төрийн зорилго болон үндэслэлтэй нь нягт уялдан байдаг.</p>
---	-------------	--

<p>Энэхүү арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх нь сайн нөлөөтэй.</p>	<p>Үгүй</p>	<p>Тийм. Эдгээр арга хэрэгслүүд нь КНХ-ын талаар сайн жишээнд орж байна.</p>
--	-------------	--

6. ХАРЬЦАА ХОЛБОО БА МЭДЛЭГ ОЙЛГОЛТ БИЙ БОЛГОХ

<p>Төрийн зүгээс энэхүү сэдвийг олон нийгэд таниулж байна уу?</p>	<p>Үгүй. Төрийн зүгээс КНХ-ын асуудлаар олон нийтийг мэдээлээр хангах, мэдлэг ойлголт өгөх чиглэлээр тодорхой санаачилсан ажил харгалдахгүй байна.</p>	<p>Тийм. ЗГ-аас КНХ-ын талаар цол мэдээлэл агуулсан цахим хуудас ажиллуулдаг. БШЦГ нь КНХ-ын ач холбогдлыг аж ахуйн нэгжүүдэд ойлгуулах, мэдлэг олгох чиглэлээр идэвхтэй ажилладаг.</p>
---	--	---

<p>Төрийн зүгээс КНХ-ын оролцогч нарыг идэвхтэй татан оролцуулдаг уу?</p>	<p>Үгүй</p>	<p>Тийм. Оролцогч нарт ил тод мэдээлэл олгохын зэрэгцээ оролцогчидтой идэвхтэй хамтарч ажиллан, тэдний сонирхлыг болгогод тусгадаг.</p>
---	-------------	---

<p>Төр нь КНХ-ын харилцаа холбооны маш сайн стратегитай юу?</p>	<p>Үгүй</p>	<p>Тийм. БШЦГ нь бизнесийн секторын нэгжүүдтэй бөгөөд тэдгээрээр дамжуулан оролцогчидтой шууд харилцдаг.</p>
---	-------------	--

7. ҮНЭЛЭХ ДҮГНЭХ

<p>КНХ-ын боллогыг тогтмол үнэлгээ хийдэг үү?</p>	<p>Үгүй. КНХ-ын төрийн боллого гаргагүй бөгөөд үнэлгээ хийх ажлын тухайд рихиад эрт байна.</p>	<p>Тийм. 2004, 2009 онд КНХ-ын талаар тайлан гаргасан. Гэхдээ тогтсон системтэй үнэлээний хэлбэр харвагдахгүй байна.</p>
---	--	--

<p>Үнэлгээ дүгнэлт өгөх ажил төлөвлөгдсөн үү?</p>	<p>Үгүй</p>	<p>Үгүй.</p>
<p>Тодорхой зорилгууд бүхий үнэлэлт дүгнэлт өгөх ажил хийгдсэн эсвэл яг одоо хийгдэж байгаа бөгөөд гарсан үр дүн нь стратегиа цаашид хөгжүүлэхэд тусгалаа олох уу?</p>	<p>Үгүй</p>	<p>Үгүй.</p>

(34) Төр хувийн хэвшлийн туншлагийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг. УИХ-ын 64-р тогтоол, 2009.10.15

Хавсралт 2.

КНХ-ын асуудлаар дүн шинжилгээ хийсэн хууль

ТОГТООМЖИЙН ЖАГСААЛТ

№ Хууль тогтоомжийн нэр, батлагсан он

1	Монгол Улсын Үндсэн хууль, 1992.01.13
	Ил тод байдал, жөндөрийн тэгш байдал, авлигын эсрэг хууль тогтоомж
2	Авлигын эсрэг хууль, 2006.07.06
3	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, 2011.06.16
4	Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 2011.02.02
	Татвар, даатгал, эдийн засгийн хүрээний хууль тогтоомж
5	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006.06.29
6	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001.02.01
7	Гаалийн тухай хууль, 2008.05.20
8	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008.05.20
9	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, 1993.05.10
10	Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, 2007.07.27
11	Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, 2012.02.10
12	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, 2002.04.25
13	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2001.12.03
14	Нийгмийн даатгалын тухай хууль, 1994.05.31
15	Нөхөрлөлийн тухай хууль, 1995.05.11
16	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006.06.29
17	Компанийн тухай хууль, 2011.10.06
18	Өрсөлдөөний тухай хууль, 2010.06.10
19	Үрийн таривалгийн даатгалын тухай хууль, 1999.07.02
20	Үйлдвэрлэл, технологийн паркын эрх зүйн байдлын тухай хууль, 2009.12.17
21	Татварын ерөнхий хууль, 2008.05.20
22	Татварын өршөөл үзүүлэх тухай хууль, 2008.02.06
23	Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хууль, 2007.12.28
24	Тариалангийн тухай хууль, 2004.04.22
25	Чөлөөт бүсийн тухай хууль, 2002.06.28
26	Хоршооны тухай хууль, 1998.01.08
27	Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль, 1995.10.24
	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж
28	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай
	Хөдөлмөрийн хууль тогтоомж
29	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, 2001.04.12

30 Хөдөлмөрийн тухай хууль, 1999.05.14

31 Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай, 2010.04.16

32 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011.06.17

33 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008.05.22

Байгаль орчны хууль тогтоомж

34 Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай, 2003.11.28

35 Байгаль орчныг хамгаалах тухай /1995/

36 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай /1998/

37 Газрын тухай /2002/

38 Газрын төлбөрийн тухай /1997/

39 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай /1994/

40 Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай /1997

41 Усны тухай /2004/

42 Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн тухай /1995/

43 Ойн тухай /2007/

44 Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн тухай /1995/

45 Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай /1996/

46 Байгалийн ургамлын тухай /1995/

47 Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай /1995/

48 Ургамал хамгааллын тухай /2007/

49 Ан агнуурын тухай /2000/

50 Амьтны аймгийн тухай /2000/

51 Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай ад зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай /2002/

52 Ангуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай /2006/

53 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай /2000/

54 Газрын хэвлийн тухай /1988/

55 Ашигт малтмалын тухай /2006/

56 Газрын тосны тухай /1991/

57 Газрын тосны бүтээгдэхүүний тухай /2005/

58 Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай /2009/

59 Агаарын тухай /2010/

60 Агаарын бохирдлын төлбөрийн тухай /2010/

61 Ус цаг уур, орчны шинжилгээний тухай /1997/

62	Химийн хорт болон аюултай бодисын тухай /2006/
63	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай /2003/
64	Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай /2000/
65	Хувиргасан амьд организмн тухай /2007/
66	Төрийн хяналт шалгалтын тухай /2003/
67	Цөмийн энергийн тухай /2009/
68	Хот, сууринны ус хангамж, ариутгах татуурын ашиглалтын тухай /2011/
69	Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай /2002/
70	Рашааны тухай /2003/
71	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай /1993/
72	Захирааны харуулалтын тухай /1992/
73	Патентын тухай /2006/
74	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай /1994/
75	Технологи дамжуулах тухай /1998/
76	Ариун цэврийн тухай /1998/
77	Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай /1999/
78	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэлийн эртэлгэд хяналт тавих тухай /2004/
79	Эрүүгийн хууль /2002/
Үндэсний хөтөлбөр	
1	МУ-ын МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, УИХ-ын 2008 оны 12-р тогтоол
2	МУ-д Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2003 оны 41-р тогтоол
3	Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай, УИХ-ын 2011 оны 30-р тогтоол
4	"Монгол мал" үндэсний хөтөлбөр, 2010 оны 23-р тогтоол
5	МУ-ын Засгийн газрын мөрийн хөтөлбөр 2008-2012, УИХ-ын 2008 оны 35-р тогтоол
6	Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги, МУ-ын 31-ын 2011 оны 36-р тогтоол
7	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр, 31-ын 2005 оны 64-р тогтоол
8	Үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, хөгжүүлэх үндсэн чиглэл, УИХ-ын 2003 оны 54-р тогтоол
9	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, УИХ-ын 2010 оны 34-р тогтоол
10	Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, 31-ын 2009 оны 299-р тогтоол

Ашигласан материал

1.	Бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь ТББ-ын оролцоо: Эрх зүйн орчин ба институтчилал, Я. Бямбажав, ННХ, 2007 он.
2.	Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 2008-2012, www.orep-govt.mn
3.	КНХ-ын талаарх хууль, тогтоомжууд, www.legalinfo.mn
4.	Компаний Нийгмийн Харуулалтын тайлан, МУХАҮТ, Улаанбаатар, 2007
5.	Монгол Улсын авлигын индексийн 2009 оны тооцооны үр дүнгийн тайлан, Монгол Улсын Авлигатай тэмцэх газар, Судалгаа шинжилгээний алба, Улаанбаатар хот 2010.
6.	Монголын эдийн засагт хувьчлалын үзүүлсэн нөлөө, Улаанбаатар, 2011
7.	Монголын компаниудын нийгмийн харуулалтын тайлан, МУХАҮТ, 2007
8.	Монголын Хүний Хөгжлийн Илтгэл 2011, НҮБЕХХ
9.	Манганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, 2008.01.31
10.	Манганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, үндэсний гурав дах илтгэл, Улаанбаатар хот, 2009 он.
11.	Нийгмийн халамж, хамгааллын чиглэлээр нам, эвслүүдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт хийсэн харьцуулсан судалгаа (2008-06-24), доктор Ц. Батсүх.
12.	Өнөдөр сонин, 2008 оны 9 сарын 3, Балдоржийн нэрэмжит "Эко танхим", Байгаль орчны дэд сайд Д.Дэлгэрцогт
13.	Өрсөлдөх чадвар ба Компанийн нийгмийн харууллага, ГОУХАН, ЭТИС хөтөлбөр, 2011.
14.	Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгаа, 2007.07-2008.06 сар, УСХ
15.	Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги, 31-ын 2011 оны 36-р тогтоол, 3.2.1
16.	Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллого: нэгдсэн дүн, УСХ, Улаанбаатар, 2011
17.	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБЕХХ, УБ, 2011, 39-р тал
18.	Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хороо, НҮБЕХХ, УБ, 2011, 71-80-р тал
19.	Saravalliy Reviews, Department for Business Innovation and Skills Saravalliy Action Plan, March 2012
20.	Corporate Responsibility Report, Department for Business, Enterprise and Regulatory Reform, UK 2009
21.	Corruption Perceptions Index 2010, Transparency International
22.	CSR and Competitiveness European SMEs' Good Practice, National Report Germany, Bonn, 2007
23.	CSR Navigator: Public Policies in Africa, the Americas, Asia and Europe, GTZ and Bertelsmann Stiftung, 2007.
24.	Daniel Kaufman, Aart Kraay and Massimo Mastuzzi (2010). "The Worldwide Governance Indicators: A Summary of Methodology, Data and Analytical Issues". World Bank Policy Research Working Paper No. 5430.